

Хавсралт 4

Монгол улсын татварын мэргэжсэн нягтлан бодогчийн хуулийн нэг бүрчилсэн тайлбар

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл

Тайлбар

Аливаа улс ТМНБ-ийн систем нэврүүлдгийн гол зорилго нь зан байдал, ур чадварын хувьд тэнцэх этгээд татвар төлөгчийг төлөөлөн татварын холбогдолтой ажил гүйцэтгэж, татвар төлөгчийн итгэлийг хүлээн хууль тогтоомжид заасан татвар төлүүлэх үүргийг үнэн зөв биелүүлэхийн төлөө ажилласнаар татвараа өөрөө тодорхойлох системийн саадгүй, зүй ёсны хэрэгжилтийг хангахад тэд зохих хувь нэмэр оруулдагтай холбоотой.

ТМНБ-ийн хуулинд ТМНБ-ийн ажил нь ийнхүү нийгэм, олон нийтийн шинжтэй байдгийг харгалзан ТМНБ-ийн ажлыг зөвхөн ТМНБ л эрхэлдэг болгосноор ТМНБ-д ажлынх нь хүрээнд онцгой эрх олгохын хамт үүрэг хүлээлгэх тухай заасан.

Тийм ч учраас татвар төлөгчийн итгэлийг хүлээн ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулахад түүнд ямагт бие даасан, шударга голч байр суурин дээр байх шаардлага тавигддаг. Мөн ТМНБ нь татварын мэргэжилтнийхээ хувьд өөрийн бат итгэл дээр тулгуурлан ямагт шударга голч, үнэн зөв дүгнэлт гаргаж байх ёстой нь зүйн хэрэг юм.

"Татварын мэргэжилтнийхээ хувьд бие даасан, шударга голч байр суурин дээр байна" гэсэн заалт нь энэхүү санааг гаргах гэсэн хэрэг юм.

Тус зүйлд ТМНБ нь үйл ажиллагаа явуулахдаа ямагт бие даасан, шударга голч байр суурин дээр байж, татвар төлөгчийн итгэлийг хүлээн татварын хууль тогтоомжид заасан татвар төлөх үүргийн зохих биелэлтийг хангахын төлөө ажиллах явдал нь ТМНБ-ийн эрхэм зорилго болох тухай заахын зэрэгцээ мөн энэхүү хуулийг тайлбарлахад үндэслэх үндсэн зарчмуудыг гаргаж тавьсан болно.

Хоёрдугаар зүйл

Тайлбар

(1) ТМНБ-ийн эрхлэх ажил

"ТМНБ-ийн эрхлэх ажил" гэдэг нь бусад этгээдийн хүсэлтээр

татвар (Татварын ерөнхий хуульд заасан татвар, хураамж, төлбөрийг хэлэх бөгөөд үүнд гаалийн татвар хамаарахгүй болно. Цаашид мөн адил)–ын талаар тус зүйлд заасан мэргэжлийн ажил эрхлэхийг хэлнэ.

Энд өгүүлэх "мэргэжлийн ажил" гэдэг нь тус зүйлд заасан ажлыг давтан үргэлжлүүлж явуулах буюу давтан үргэлжлүүлж явуулах зорилго өвөрлөн явуулахыг хэлэх бөгөөд заавал ч үгүй төлбөртэй явуулах албагүй.

Энэ нь жишээлбэл, хэн нэгэн наймаачин үйлчлүүлэгчиддээ татварын мэдлэг бүхий хүнийг хөлслөн татварын зөвлөгөө өгүүлэх тохиолдолд тус этгээдийн хүсэлтийн дагуу түүний тодорхой бус тооны үйлчлүүлэгчтэй харьцаж байх юм бол энэ нь ТМНБ–ийн эрхлэх ажил болно. Гэхдээ татварын холбогдолтой лекц, асуулт хариулт зэргийг явуулахдаа бодит зүйл рүү хөндөж оролгүй, харин татварын хуулийн агуулгыг ерөнхийд нь тайлбарлах явдал нь ТМНБ–ийн эрхлэх ажилд хамаарахгүй юм. Мөн ямар нэгэн компанид хөлслөгдөн ажиллаж буй этгээд компанийхаа татварын холбогдолтой бичиг баримт боловсруулах юмуу компаниа төлөөлөн татварын холбогдолтой үйл ажиллагаа явуулах шиг тодорхой нэг этгээдийн татварын холбогдолтой үйл ажиллагааг явуулах явдал нь ТМНБ–ийн эрхлэх ажил биш юм.

Гэхдээ пүүс компани зэрэг тодорхой нэг этгээдийн энэ дугааруудад заасан татварын холбогдолтой ажил гүйцэтгэж байгаа хэдий ч үүний цаагуур бодит байдал дээр ТМНБ–ийн үйл ажиллагаа явуулж байгаатай ижил үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд энэ нь ТМНБ–ийн үйл ажиллагаа явуулж буй хэрэг болно.

(2) ТМНБ–ийн үйл ажиллагааны объект болох татварын төрөл

ТМНБ нь үндсэндээ улсын болон орон нутгийн бүх татвараар үйл ажиллагаа явуулж болно. Гэхдээ ТМНБ–ийн хэрэгцээ нэг их шаардлагагүй татварын төрөл юмуу ТМНБ–ийн ажилд тохирохгүй гаалийн татвар ТМНБ–ийн үйл ажиллагааны объектод орохгүй болно.

(3) Татварын холбогдолтой үйл ажиллагаа төлөөлөн явуулах

"Татварын холбогдолтой үйл ажиллагаа төлөөлөн явуулах" гэдэг нь УТЕГ болон бусад шатны татварын байгууллагад хандаж татварын холбогдолтой хууль тогтоомжийн дагуу тайлан, өргөдөл, нэхэмжлэл, мэдэгдэл, мэдээ, гомдол гаргах болон үүнтэй адилтгах үйлдэл

(цаашид "тайлан мэдээ" гэх), эсвэл тухайн тайлан мэдээ болон ҮТЕГ, бусад шатны татварын байгууллагаас явуулсан шалгалт, авч явуулсан арга хэмжээтэй холбогдуулан тус байгууллагуудад санал болон тайлбар дүгнэлт гаргах үйл ажиллагааг төлөөлөн болон орлон гүйцэтгэхийг хэлнэ.

"Төлөөлөн гүйцэтгэх" гэдэг нь ажил төлөөлөн гүйцэтгэгч этгээд нь тухайн этгээдийг төлөөлөн хууль зүйн үйлдэл (Хүсэл зоригоо илэрхийлэх болон үүний нэгэн үйлдэл үйлдэхийг шаардах болон татгалзах гэх мэт үйлдэл) явуулах, эсвэл хууль зүйн үйлдэл хүлээн авах үйлдлийг хэлэх бөгөөд үүний хууль зүйн үр дагавар нь шууд тухайн этгээдийнх болно. Энэ нь хууль зүйн үйлдэл дээр хэрэглэгддэг ойлголт юм. Харин "Орлон явуулах" гэдэг нь тухайн этгээдийг орлон бодит ажил гүйцэтгэхийг хэлнэ.

Гэсэн ч ТМНБ татвар төлөгчийн төлөө "татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулах" үед бодит байдал дээр их гардаг нэг асуудал бол татварын хяналт шалгалтын үеэр ТМНБ нь татвар төлөгчийн тусын тулд байдлыг тайлбарлан ойлгуулах, санал дүгнэлтээ хэлэх зэрэг хууль зүйн үйлдэл гэж үзэмгүй үйлдлээр тухайн этгээдэд туслалцаа үзүүлдэг явдал юм. Ийм үйлдэл ТМНБ-ийн ажилд хамаарахгүй гэж үзвэл энэ нь татвар төлөгч болон ТМНБ-ийн хүсэн хүлээсэн зүйлийн эсрэг болох билээ. Иймээс ийм байдалд хүргэхгүйн үүднээс тус зүйлийн 1-р хэсгийн 1-д "Татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулах" гэдэгт хууль зүйн үйлдэл " төлөөлөн явуулах" төдийгүй бодит үйлдлийг "орлон явуулах" явдал ч бас багтах тухай гаргаж өгсөн билээ. Харин "саналаа хэлэх", "дүгнэлт тайлбар гаргах" хоёрын тухайд авч үзвэл ерөнхийдөө эхнийх нь өөрийн саналыг идэвхтэй илэрхийлэх гэсэн утгатай бол дараагийнх нь зөвхөн "саналаа илэрхийлэх" төдийгүй бодит байдлыг тайлбарлах гэсэн санааг ч бас багтаах бөгөөд ТМНБ татвар төлөгчийг төлөөлөн ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад хандах үед татварын мэргэжилтнийхээ хувьд саналаа илэрхийлэх, дүгнэлт тайлбар өгөх явдал байнга гарч байх зүйл гэдгийг бодолцож үзвэл "саналаа илэрхийлэх", "дүгнэлт тайлбар өгөх" хоёрыг хүчээр зааглах нь утгагүй хэрэг юм. Бодит зүйлийг тайлбарлан ойлгуулахын тухайд авч үзвэл энэ нь татварын бодит өртэй холбоогүй зүйл бол "татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулах" гэдэгт оруулах нь тохирохгүй талтай. Гэхдээ ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад хандаж гаргах татварын холбогдолтой тайлбар дотор татварын өртэй холбоогүй зүйл хийсвэрээр байж болох боловч бодитойгоор орших үндэсгүй юм.

(4) Татварын холбогдолтой бичиг баримт боловсруулах

"Татварын холбогдолтой бичиг баримт боловсруулах" гэдэг нь ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад хандаж тайлан мэдээ гаргахад шаардлагатай тайлан, өргөдөл, нэхэмжлэл, мэдэгдэл, мэдээ, тооцооны дэвтэр, лавлах, гомдлын бичиг болон эдгээртэй адилтгах бичиг баримт (цаашид "тайлан, бусад бичиг баримт" гэх) боловсруулахыг хэлнэ.

Энэхүү тайлан, бусад бичиг баримт нь татварын холбогдолтой хууль тогтоомжид үндэслэн хийгдсэн ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад гаргах бичиг баримт байх ёстой.

Төрөл бүрийн санхүүгийн бичиг баримт нь татварын хуулийн шаардлагад нийцүүлэн хийгдсэн зүйл угаасаа биш тул энэхүү тайлан, бусад бичиг баримтад хавсарган тушаахыг шаардлаа ч энд өгүүлэх "тайлан, бусад бичиг баримт"-д хамаарахгүй юм.

"Бичиг баримт боловсруулах" гэдэг нь дээрх бичиг баримтыг өөрийн дүгнэлтэнд тулгуурлан боловсруулахыг хэлэх бөгөөд зөвхөн төлөөлөн боловсруулсан төдий зүйл үүнд хамаарахгүй болно.

(5) Татварын холбогдолтой зөвлөгөө өгөх

"Татварын холбогдолтой зөвлөгөө өгөх" гэдэг нь ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад хандаж гаргах тайлан мэдээ, тус зүйлийн 1-р хэсгийн 1-д заасан санал, тайлбар дүгнэлт, тайлан, бусад бичиг баримт боловсруулахад татварын холбогдолтой зөвлөгөө өгөхийг хэлнэ. "Зөвлөгөө өгөх" гэдэг нь асуултанд бодитойгоор хариулж, заавар өгч, саналаа хэлэх явдал бөгөөд татвар төлөгчийн бодит үйл ажиллагаан дээр авч явуулах шаардлагатай. Харин татварын хуулийн ерөнхий тайлбар, лекцэн дээр хийсвэр жишээ татан татварын хувь хэмжээг бодож тооцох бодлого бодох зэрэг нь энд өгүүлэх "татварын холбогдолтой зөвлөгөө өгөх" гэдэгт хамаарахгүй болно.

(6) ТМНБ-ийн дагалдах ажил

ТМНБ нь ТМНБ-ийн ажлаас гадна ТМНБ-ийнхоо нэрийг ашиглан бусад этгээдийн хүсэлтээр ТМНБ-ийн ажлын хажуугаар санхүүгийн бичиг баримт боловсруулах, данс бүртгэл хөтлөх болон үүнээс бусад санхүүгийн холбогдолтой ажлыг мэргэжлийн хүрээнд явуулж болно. Гэхдээ бусад хууль тогтоомж дахь мэргэжлийн хүрээний ажлын хүрээнд явуулахыг хязгаарласан заалт үүнд хамаарахгүй болно.

Энэхүү заалтыг гаргаж ирсний учир бол татварын хуулинд үндэслэн хийдэг татварын тооцоо нь аж ахуйн нэгж, байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл дээр тулгуурлан хийгддэг зүйл тул бодит байдал дээр ТМНБ-ийн хийж буй ажил нь санхүүгийн бичиг баримт

боловсруулах болон хөтлөх ажлыг төлөөлөн явуулахтай тун ойрхон холбоотой бөгөөд үнэндээ эдгээр ажлын хажуугаар ТМНБ-ийн ажлыг хавсарч хийж буй хэрэг билээ. Иймээс татварын бичиг баримт боловсруулах, татварын зөвлөгөө өгөх гэх мэт ажил итгэмжлэн хийлгүүлж буй татвар төлөгчийнхөө санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой ажлыг ТМНБ-ийн ажлынхаа хажуугаар хавсран хийж болохыг ийнхүү баталж тодорхой болгосноор ТМНБ-ийг татварын нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнийх нь хувьд байр суурийг нь өсгөх гэсэн хэрэг юм.

Мөн санхүүгийн бичиг баримт боловсруулах, нягтлан бодох бүртгэл хөтлөх зэрэг санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажил нь бие даасан ажил бөгөөд уг заалт нь энэхүү санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажлыг бие даасан ажил болох ТМНБ-ийн ажилд оруулан үзэх гээгүй нь "ТМНБ-ийн эрхлэх ажлаас гадна", "ТМНБ-ийн ажилтайгаа хавсран" гэсэн хэллэгээс тодорхой харагдаж байна.

Мөн энэхүү заалтыг оруулж ирснээр ТМНБ нь ТМНБ-ийн ажил итгэмжлэн хийлгэгч этгээдээс бусад этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажил хийх явдал хязгаарлагдана гэсэн үг бус нь ойлгомжтой.

ТМНБ нь хэдийгээр санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажил хийж байлаа ч санхүүгийн бичиг баримтад шалгалт хийх нотлохыг хязгаарласан шиг бусад хууль тогтоомжид хязгаарласан зүйлийг мэдээж хийж болохгүй.

Гуравдугаар зүйл

Тайлбар

(1) ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн этгээд

ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн этгээд нь ТМНБ болох эрхтэй тухай хамгийн түрүүнд авч үзсэн билээ. Энэ нь ТМНБ болох эрх бүхий этгээдэд ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн этгээдийг голлон авч үзэх тухай санааг гаргах гэсэн хэрэг юм.

ТМНБ болохын тулд дараачийн удаад ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн, эсвэл ТМНБ-ийн бүх шалгалтаас чөлөөлөгдсөн байх шаардлагатай.

ТМНБ-ийн шалгалт нь ТМНБ болоход шаардлагатай мэдлэг, практик чадвар буй эсэхийг тогтоох зорилготой бөгөөд татварын хуулийн холбогдолтой шалгалт, санхүү, нягтлан бодох бүртгэлийн шалгалт, практик дадлагын шалгалт гэсэн шалгалтаас бүрдэнэ. Мөн ТМНБ-ийн зарим нэг шалгалтанд тэнцсэн тохиолдолд дараачийн удаад явагдах ТМНБ-ийн шалгалтын тухайн шалгалтаас чөлөөлөгдөж болох тул чөлөөлөгдөх шалгалтаас бусад шалгалтанд тэнцсэн

тохиолдолд ТМНБ болох эрхтэй болох юм.

(2) ТМНБ-ийн бүх шалгалтаас чөлөөлөгдсөн этгээд

ТМНБ болох эрх бүхий этгээдийн хоёрдугаарт ТМНБ-ийн бүх шалгалтаас чөлөөлөгдсөн этгээдийг авч үзсэн. Тухайн этгээдийн мэргэшил, ажилласан жилийг харгалзан ТМНБ-ийн зарим шалгалт болон бүх шалгалтаас чөлөөлж болно. Мөн шалгалтанд нэг удаа тэнцсэн тохиолдолд дараачийн удаад явагдах ТМНБ-ийн тухайн шалгалтаас чөлөөлнө. ТМНБ-ийн бүх шалгалтаас чөлөөлөгдсөн этгээд нь ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн этгээдтэй нэгэн адил ТМНБ болох эрхтэй болно.

Жишээлбэл, мэргэжсэн нягтлан бодогчийн эрхтэй этгээд нь ТМНБ-ийн шалгалтын санхүү, нягтлан бодох бүртгэлийн шалгалтаас чөлөөлөгдөх бөгөөд мөн тодорхой хугацаагаар татварын холбогдолтой ажил хийж, татварын хуулийн шалгалтаас чөлөөлөгдсөн этгээд нь мэргэжсэн нягтлан бодогчийн эрхтэй болсон тохиолдолд ТМНБ-ийн бүх шалгалтаас чөлөөлөгдөнө. Урьдах ТМНБ-ийн шалгалтан дээр татварын хуулийн шалгалтанд тэнцэж, ТМНБ-ийн зарим шалгалтаас чөлөөлөгдсөн этгээд нь мэргэжсэн нягтлан бодогчийн эрх авсан тохиолдолд ТМНБ-ийн бүх шалгалтаас чөлөөлөгдөнө гэж үзэн ТМНБ-ийн эрх олгоно.

Гэхдээ ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн этгээд болон ТМНБ-ийн бүх шалгалтаас чөлөөлөгдөж ТМНБ болох эрх олж авсан этгээд нь татварын холбогдолтой ажил нийтдээ 2-оос доошгүй жил, эсвэл санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой ажил нийтдээ 5-аас доошгүй жил хийсэн байх шаардлагатай.

Энд өгүүлэх " татвар болон санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой ажил" гэдэг нь ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагаас бусад төр, олон нийтийн байгууллага, пүүс компани зэрэг газар татвар болон санхүүгийн холбогдолтой ажил (Тайлан баланс, ашиг алдагдлын данс бүртгэл хөтлөх ажил бөгөөд ямар нэгэн тусгай дүгнэлт шаардлагагүй, механик ажил үүнд хамаарахгүй болно.)-ыг хэлж буй бөгөөд ажилласан жилийн хугацааг авч үзэхдээ ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн үед болон ТМНБ-ийн бүх шалгалтаас чөлөөлөгдөх тухай шийдвэр гарахаас өмнө ба хойдох хугацаагаар тогтооно.

Дөрөвдүгээр зүйл

Тайлбар

ТМНБ нь татвар төлөгчийн итгэлийг хүлээн татварын хуулинд заасан татвар төлөх үүргийг үнэн зөв биелүүлэх явдлыг эрхэм зорилго

болгодог бөгөөд ТМНБ болох эрх олж авсан байлаа ч тус зүйлд заасан аль нэг дугаарт хамаарагдах этгээд нь ТМНБ болох эрхгүй юм.

Мөн ТМНБ-оор бүртгүүлсэн этгээд нь тус зүйлийн аль нэг дугаарт хамаарагдах болсон тохиолдолд тус этгээдийг нэн даруй бүртгэлээс хасч (20-р зүйл), ТМНБ-ийн эрхийг нь хасна.

(1) 3-аас 5 хүртэлх дугаарт ТМНБ болох эрхгүй этгээдийн тухай заасан бөгөөд ТМНБ нь татвар төлөгчийн итгэлийг хүлээн чухал ажил хэрэг гүйцэтгэх хэрэг тул ийм чадваргүй хүн ТМНБ-д тэнцэхгүй нь мэдээж юм.

"*Насанд хүрээгүй этгээд*" гэдэг нь бүтэн 18 нас хүрээгүй этгээдийг хэлнэ.

"*Сэтгэл мэдрэлийн өвчтэй этгээд*" гэдэг нь өөрийн үйлдэлд дүгнэлт хийх чадваргүй, сэтгэл мэдрэлийн өвчтэй гэсэн шүүхийн тогтоол гарч, энэхүү тогтоолын үйлчлэх хугацаа дуусаагүй байгаа этгээдийг хэлнэ.

"*Сэтгэл мэдрэлийн өвчтэй этгээдтэй адилтгах этгээд*" гэдэг нь өөрийн үйлдэлд дүгнэлт хийх чадвар муу, хөрөнгө мөнгөнд үрэлгэн ханддагийн улмаас шүүхээс сэтгэл мэдрэлийн өвчтэй этгээд болох тухай тогтоол гарч, тэрхүү тогтоол үйлчилж буй этгээдийг хэлнэ.

"*Төлбөрийн чадвараа алдсан этгээд*" гэдэг нь төлбөрийн чадвараа алдсан тухай шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гарч, өрийг нь төлж барагдуулах юмуу бусад аргаар өрийг бүхэлд нь буюу хагасыг нь хүчингүй болгож, шүүхээс тус эрх нь сэргээгдээгүй байгаа этгээдийг хэлнэ.

(2) 4, 5 дугааруудад улсын болон орон нутгийн албан татварын хууль, ТМНБ-ийн хуулийн дагуу ял шийтгэл шийтгүүлсэн этгээдийн тухай заасан бөгөөд эдгээр хууль тогтоомжийн дагуу ял шийтгүүлсэн этгээдийг бусад хууль тогтоомжор ял шийтгүүлсэн этгээдээс ялгаатай авч үзнэ. Ялангуяа ТМНБ нь эдгээр татварын хууль тогтоомжийн эсрэг үйлдэл үйлдсэн тохиолдолд тодорхой хугацаагаар ТМНБ-ийн эрхийг нь хасах хариуцлага хүлээлгэнэ. Өөрөөр хэлбэл, улсын болон орон нутгийн албан татварын хууль болон ТМНБ-ийн хуулиар хорих ялаас дээш хэмжээний ял шийтгүүлсэн этгээдийг тус ялыг эдэлж дууссан болон тус ялыг эдлэхгүй болсон өдрөөс 5 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй тохиолдолд ТМНБ болох эрхгүй гэж үзэх бөгөөд мөн улсын болон орон нутгийн албан татварын хууль, ТМНБ-ийн хуулийн дагуу торгох ял шийтгэгдэж, уг ял шийтгэгдсэн өдрөөс 3 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй этгээд нь ТМНБ болох эрхгүй юм.

"*Хорих ялаас дээш хэмжээний ял*" гэдэг нь хорих ял, хүнд хөдөлмөр хийлгэх хорих ял болон цаазаар авах ялыг хэлнэ.

"*Ял эдэлж дууссан*" гэдэг нь торгох ялын хувьд авч үзвэл тухайн

торгуулиа төлж дуусалгүй хөдөлмөр засан хүмүүжүүлэх газар хоригдож буй тохиолдолд ялын хугацаагаа эдэлж дуусахыг хэлэх бөгөөд мөн хорихоос батлан даалтаар гарч, батлан даалтанд байх хугацаанд нь ялын хугацаа нь дууссан тохиолдлыг хэлнэ.

Харин хорих болон хүнд хөдөлмөр хийлгэх хорих ялын тухайд авч үзвэл тус ялын хугацаа дуусахыг хэлэх бөгөөд мөн хорих газраас батлан даалтанд байх хугацаанд нь ялын хугацаа дуусах тохиолдлыг хэлнэ.

"Ял эдлэхгүй болсон" гэдэг нь хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар ял эдлэхгүй болсон, гадаад оронд шийтгүүлсэн ялыг бүхэлд нь буюу заримыг нь эдэлж хөнгөлөлт эдэлсэн болон ялаас чөлөөлөгдөж ял эдлэхгүй болсон, өршөөл үзүүлэх үеэр хөнгөлөлт эдэлж буюу ялаас чөлөөлөгдсөн, ялын хөнгөлөлтөөр ял эдлэхгүй болсон болон ялаас чөлөөлөгдөхийг хэлнэ. Гэхдээ ял хойшлуулах таслан шийдвэрлэх тогтоол гарсан хугацаанд ял эдлэхгүй болсон гэсэн заалтад хамаарахгүй бөгөөд ял хойшлуулах тогтоол цуцлагдаагүй үед энэхүү ялын хугацаа дуусвал ялын тогтоол хүчингүй болох тул анхнаасаа ял шийтгүүлээгүй хэрэг болж, ялын хойшлогдсон хугацаа дуусахтай хамт энэхүү ТМНБ болох эрхгүй болох тухай заалтад хамаарахгүй болно. Мөн өршөөлөөр ял шийтгэл эдлэх тухай таслан шийдвэрлэх тогтоол гарахтай зэрэг нэгэн адил ТМНБ болох эрхгүй болох тухай заалтад хамаарахгүй болно.

(3) 6-рт улс, орон нутгийн албан татварын хууль, ТМНБ-ийн хуулиас бусад хуулийн заалтын дагуу ял шийтгэл шийтгүүлсэн этгээдийн тухай заасан бөгөөд энэ тохиолдолд хорих ялаас дээш хэмжээний ял эдэлсэн тохиолдолд тус ялыг эдэлж дууссан болон эдлэхгүй болсон өдрөөс 3 хүртэлх жилийн хугацаанд ТМНБ болох эрхгүй болно.

(4) 7,8-рт сахилгын арга хэмжээ шийтгүүлсэн ТМНБ, төрийн албан хаагч зэрэг этгээдийн тухай заасан бөгөөд ТМНБ нь сахилгын арга хэмжээгээр бүртгэл хүчингүй болгох, бүртгэлээс хасагдах зэрэг арга хэмжээ шийтгүүлсэн өдрөөс 3 хүртэлх жилийн хугацаанд, төрийн албан хаагчийн ажлаас халагдсан этгээдийн хувьд ажлаас халагдах арга хэмжээ шийтгүүлсэн өдрөөс 3 хүртэлх жилийн хугацаанд ТМНБ болох эрхгүй юм.

"Сахилгын хариуцлага" гэдэг нь төрийн албан хаагчийн тухайн хуулинд заасны дагуу сахилга бат сахих үүргээ биелүүлээгүй этгээдийг шийтгэх шийтгэл юм.

(5) 9-рт

① Сахилгын хариуцлагаар өмгөөлөгч, мэргэжсэн нягтлан бодогчийн ажил эрхлэхээ зогсоох арга хэмжээ шийтгүүлж, одоо тус шийтгэл шийтгүүлж буй этгээд (Хуулийн 18–р зүйлийн 1–р хэсгийн 1)

- Шударга бус арга замаар татвар ногдуулалт, татвар хураалтаас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан, мөн зайлсхийх боломж олгосон болон зайлсхийх боломж олгохыг завдсан үйлдэл үйлдсэн өдрөөс 5 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй этгээд (Тус хуулийн тус зүйлийн 3)
- Шударга бус замаар татвар буцаан авсан болон авах гэсэн, мөн татвар буцаан авах боломж олгосон болон олгох гэсэн үйлдэл үйлдсэн этгээдийн уг үйлдэл болсон өдрөөс 5 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй этгээд (Тус хуулийн тус зүйлийн 5)
- Татвар болон санхүүгийн холбоотой ажил хийж байх үедээ эрүүгийн хуулийн эсрэг үйлдэл үйлдээд тухайн үйлдэл болсон өдрөөс 5 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй этгээд (Тус хуулийн тус зүйлийн 5)

② ТМНБ–оор бүртгүүлэх өргөдөл гаргах үедээ бүртгүүлэх зүйлийг худал бөглөж ирүүлсэн этгээд (Хуулийн 19–р зүйлийн 1–р хэсэг)

③ Тухайн ТМНБ–ийн өөрийх нь болон харилцагч татвар төлөгчийх нь татварын тайлан болон татварын холбогдолтой бусад үйл ажиллагаа нь олон нийтийн эсрэг чиглэсэн этгээд (19–р зүйлийн 2–р хэсэг)–ийн талаар заасан бөгөөд эдгээр этгээд нь тус тусын шийтгэл шийтгүүлсэн өдрөөс 3 хүртэлх жилийн хугацаанд ТМНБ болох эрхгүй юм.

*Тавдугаар зүйл
Шалгалт өгөх эрх*

Тайлбар

(1) ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад ажиллаж байсан этгээд

ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад улс, орон нутгийн татвар хариуцан нийтдээ 3–аас доошгүй жил ажиллаж байсан этгээд шалгалт өгөх эрхтэй.

"ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад хийсэн ажил" гэдэг нь ҮТЕГ болон бусад шатны байгууллагад хийсэн ажлыг хэлж буй бөгөөд эдгээр төрийн байгууллагад ажиллаж байсан л бол татвар ногдуулалт, татвар хураалт гэж хязгаарлахгүй болно.

(2) Монгол улсын мэргэжсэн нягтлан бодогч болон өмгөөлөгч

Монгол улсын мэргэжсэн нягтлан бодогч болон өмгөөлөгч нь шалгалт өгөх эрхтэй.

Шалгалт өгөх эрхтэй мэргэжсэн нягтлан бодогч, өмгөөлөгч гэдэг нь мэргэжсэн нягтлан бодогч, өмгөөлөгчийн эрхтэй л байвал одоо тус ажлыг хийж буй эсэх нь хамаагүй.

(3) Тодорхой нэг төрийн захиргааны байгууллага, эсвэл пүүс компанид санхүү, нягтлан бодох бүртгэлийн тодорхой нэг ажил хийж байсан этгээд

Татварын байгууллагаас бусад төр, орон нутгийн засаг захиргааны байгууллагад татвар буюу санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажил нийтдээ 5-аас доошгүй жил хийсэн этгээдэд ТМНБ-ийн шалгалт өгөх эрх олгогдоно. Мөн ямарваа нэгэн пүүс компани, байгууллагад санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажил нийтдээ 5-аас доошгүй жил хийсэн этгээдэд ч мөн адил ТМНБ-ийн шалгалт өгөх эрх олгогдоно.

5-аас доошгүй жил ажилласан гэдэг нь ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад ирсэн бичиг баримтаар нотлогдсон тохиолдолд л шалгалт өгөх эрхтэй болно.

"Санхүү, нягтлан бодох бүртгэлийн тодорхой нэг ажил" гэдэг нь тайлан баланс, ашиг алдагдлын дэвтэр хөтөлж, нягтлан бодох бүртгэл тооцоо хийх ажил (Тусгай дүгнэлт хийх шаардлагагүй, ямар нэг механик ажил үүнд хамаарахгүй болно.)-ыг хэлнэ.

(4) ТМНБ нарын туслах ажил хийж байсан этгээд

ТМНБ, мэргэжсэн нягтлан бодогч, аудитын байгууллага болон өмгөөлөгчийн дэргэд туслахын ажил нийтдээ 5-аас доошгүй жил хийж байсан этгээдэд ТМНБ-ийн шалгалт өгөх эрх олгогдоно.

(5) Их, дээд сургууль дүүргэсэн этгээд

Их, дээд сургуульд татвар, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг болон хуулиар зэрэг хамгаалж төгссөн этгээд шалгалт өгөх эрхтэй.

Үүнд гадаадын их дээд сургуулиуд ч хамаарна.

"Зэрэг хамгаалсан" гэдэг нь татвар, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль (Үндсэн хууль, иргэний хууль гэх мэт) болон эдийн засаг (эдийн засгийн онол, эдийн засгийн бодлого гэх мэт)-ийн холбогдолтой нэгээс дээш хичээлд тэнцсэн этгээдийг хэлнэ. Мөн хууль, эдийн засаг, худалдааны чиглэлээр төгсөөгүй байлаа ч татвар, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль, эдийн засгийн хичээл үзсэн хүнд ч шалгалт өгөх эрх олгож болно.

(6) Мэргэжлийн зөвлөлөөс зөвшөөрөгдсөн этгээд

Мэргэжлийн зөвлөлөөс татвар, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль, эдийн засгийн талаар 1–ээс 5–д заасан этгээдтэй ижил төвшингийн болон түүнээс дээш төвшингийн мэдлэгтэй гэж мэргэжлийн зөвлөлөөс хүлээн зөвшөөрөгдсөн этгээд нь ТМНБ–ийн шалгалт өгөх эрхтэй.

Жишээ нь, 5–р зүйлийн хувьд авч үзвэл, их дээд сургуульд сурч буй хэдий ч тодорхой нэг ерөнхий мэдлэгийн хичээл дээр тодорхой оноо (Соёл судлал, нийгэм, байгалийн ухааны энэ 3 чиглэлээр нийтдээ 9 хичээлд суусан) авсан, мөн татвар, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль, эдийн засгийн холбогдолтой 1–ээс доошгүй хичээлд суусан этгээд нь ТМНБ–ийн шалгалт өгөх эрхтэй.

Мэргэжлийн зөвлөлөөс шалгалт өгөх зөвшөөрөл авах гэж буй этгээд нь сурсан сургууль, хийж байсан ажлынхаа талаар тэмдэглэсэн бичиг баримтыг ТМНБ–ийн шалгалт өгөхийг хүлээн зөвшөөрөхийг хүссэн өргөдөлдөө хавсарган мэргэжлийн зөвлөлийн даргад ирүүлнэ.

(7) Монгол улсын ҮТЕГ–аас баталсан нягтлан бодох бүртгэлийн 1–р зэрэг олгох шалгалтанд тэнцсэн этгээд

Шалгалтыг өргөн хүрээнд явуулахын тулд Монгол улсын ҮТЕГ–аас баталсан нягтлан бодох бүртгэлийн 1–р зэрэг олгох шалгалтанд тэнцсэн этгээдэд ч шалгалт өгөх эрх олгож болно.

(1) Хугацааг тооцох тухай

Ажилласан жилийг тооцохдоо ажиллаж эхэлсний дараагийн өдрөөс ТМНБ–ийн шалгалт өгөхийн өмнөх өдөр хүртэлх хугацаагаар тооцох бөгөөд хуанлийн оноор бодож тооцно.

Гэхдээ ажилласан жилийн 2 өөр заалт бүхий 2–оос дээш ажилд ажиллаж байсан тохиолдолд тус тусын ажилласан 1 жилийн үнэлгээг 10 жил гэсэн үнэлгээнд оруулан бодож, нийт ажилласан хугацааг тооцоход 10 жилээс илүү байх шаардлагатай. Жишээлбэл, ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад 2 жил, ТМНБ–ийн албан конторт туслах ажил 2 жил хийсэн гэж үзье.

Улсын татвартай холбоотой ажил 3 жил хийсэн тохиолдолд шалгалт өгөх эрхтэй тул үүнийг 10 жилд шилжүүлэн бодоход 3,3 болох бөгөөд 2 жилийн ажилласан жилийг 3,3–аар үржүүлэхэд 6,6 жил болно. Харин ТМНБ–ийн албан конторт туслах ажил 5 жил хийсэн тохиолдолд шалгалт өгөх эрхтэй болох бөгөөд үүнийг 10 жилд шилжүүлэн

тооцоход 2–оор үржүүлэхэд л хангалттай. Ингээд энэхүү ажилд 2 жил ажилласан тул 2–оор үржүүлэхэд 4 жил болно. Энэхүү 2 ажилд ажилласан жилийн нийлбэрийг гаргахад 10,6 жил болох тул тухайн этгээд нь шалгалт өгөх эрхтэй болно.

Зургадугаар зүйл
Шалгалтын зорилго болон төрөл

Тайлбар

Тус зүйлд ТМНБ–ийн шалгалтын зорилго нь ТМНБ болоход шаардлагатай мэдлэг, практик чадвар буй эсэхийг тогтооход оршиж буй тухай заасан бөгөөд татварын хуулийн шалгалтын хүн амын орлогын албан татварын хууль, аж ахуйн нэгжийн албан татварын хууль, нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн шалгалт дотроос шалгалт өгөгчийн сонгох 2 шалгалт, санхүү, нягтлан бодох бүртгэлийн шалгалт болох нягтлан бодох бүртгэл, санхүүгийн 2 шалгалт, практик дадлагын шалгалт болох практик дадлагын шалгалт болон ТМНБ–ийн шалгалт авч явуулах тухай заасан.

ТМНБ–ийн шалгалт нь ТМНБ болоход шаардлагатай мэдлэг, практик дадлагын чадвар буй эсэхийг тогтоох шалгалт тул тус шалгалтын агуулга, практик дадлагын асуултанд татварын үндсэн зарчим, татварын үндсэн онолыг ч бас тусган оруулах нь зүйтэй.

Долдугаар зүйл
Зарим шалгалтаас чөлөөлөх тухай

(Тайлбар)

ТМНБ–ийн бүх шалгалтанд заавал ч үгүй нэг удаагийн шалгалтаар тэнцэхийг шаарддаггүй, мөн шалгалт явуулах бүрд тухайн шалгалтын дүнгийн нийлбэрээр тэнцсэн, эс тэнцсэн эсэхийг тогтоодоггүй бөгөөд харин шалгалт бүрийн дүнг тусад нь гаргаж, зарим шалгалтан дээр тэнцсэн бол дараагийн удаа явагдах ТМНБ–ийн шалгалтын тухайн шалгалтаас чөлөөлнө.

Иймээс хэд хэдэн удаагийн ТМНБ–ийн шалгалтын зохих шалгалтууд дээр тэнцсэн байхад л хангалттай. Өгөх шалгалтуудаа хэд хэдэн удаа ТМНБ–ийн шалгалт өгөхөөр бодож, хуваасан ч болно.

Бүтэн 70 оноо авсан тохиолдолд тэнцсэнд тооцно.

Шалгалтанд тэнцсэн бол тэр тухай нь шалгалт өгсөн этгээдэд мэдэгдэнэ. Дараагийн удаа ТМНБ–ийн шалгалт өгөхдөө тэнцсэн шалгалтаас чөлөөлөгдөхийг хүсч буй этгээд нь тухайн чөлөөлөгдөх шалгалтаа ТМНБ–ийн шалгалт өгөх өргөдөлдөө бичиж, шалгалтаас чөлөөлөгдөх эрхтэй гэдгийг батлах бичиг болох шалгалтанд тэнцсэн

тухай мэдэгдэх хуудсыг хамт хавсаргах шаардлагатай.

Мөн ТМНБ-ийн шалгалтын төрөл нь татварын хуулийн өөрчлөлт болон цуцлалтаар нэмэгдэж хасагдах магадлалтай байдаг бөгөөд хэрвээ шалгалтанд тэнцсэний дараа татварын хууль цуцлагдсан тохиолдолд тус шалгалтыг 6-р зүйлд заасан шалгалтын төрөлтэй адилтган үзнэ.

Наймдугаар зүйл
Зарим шалгалтаас чөлөөлөх тухай

Тайлбар

ТМНБ-ийн шалгалт нь тодорхой эрх бүхий этгээдэд тэр эрхийнх нь дагуу, мөн тодорхой ажлын туршлага болон ажилласан жил зэрэг үзүүлэлтээр ТМНБ-ийн шалгалт өгөөгүй хэдий ч

ТМНБ болоход шаардлагатай мэдлэг, практик чадвар бүрэн эзэмшсэн гэж хүлээн зөвшөөрөгдсөн этгээдийг түүний хүсэлтийн дагуу тухайн мэдлэг, практик чадвар бүхий гэж хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтаас чөлөөлнө.

ТМНБ-ийн зарим нэг шалгалтуудаас чөлөөлөгдөж болох этгээд болон чөлөөлөгдөж болох шалгалтын төрлийг дор өгүүлэв.

(1) ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллага дахь ажлыг ① татвар ногдуулалт, татвар хураалт, татварын хуулийн төсөл боловсруулах ажил болон ② эдгээрээс бусад ажил гэсэн хоёр хэсэгт хувааж, ①-д заасан ажлыг нийтдээ 5-аас доошгүй жил хийсэн этгээдийг татварын хуулийн шалгалт болон практик дадлагын шалгалтаас, 10-аас доошгүй жил ажилласан этгээдийг бүх шалгалтаас чөлөөлнө. Харин ②-д заасан ажлыг 10-аас доошгүй жил хийсэн этгээдийг татварын хуулийн шалгалт болон практик дадлагын шалгалтаас, 15-аас доошгүй жил ажилласан этгээдийг бүх шалгалтаас чөлөөлнө.

(2) Их дээд сургуульд татвар, санхүү, хуулийн багшаар нийтдээ 5-аас доошгүй жил ажилласан этгээдийг татварын хуулийн шалгалтаас, харин их дээд сургуульд нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн багшаар нийтдээ 5-аас доошгүй жил ажилласан этгээдийг нягтлан бодох бүртгэлийн шалгалтаас тус тус чөлөөлнө.

(3) Мэргэжсэн нягтлан бодогчийг нягтлан бодох бүртгэлийн шалгалтаас, өмгөөлөгчийг татварын хуулийн шалгалтаас чөлөөлнө.

(4) Мэргэжлийн зөвлөлөөс тухайн этгээдийг ажлын үр дүн, чадвараар нь ТМНБ-д тэнцэнэ гэж хүлээн зөвшөөрсөн, улмаар ҮТЕГ-ын даргын зөвшөөрлийг олсон этгээдийг ихэнх шалгалтаас

чөлөөлнө. Мөн бүх шалгалтаас ч чөлөөлж болох тухай заасан.

Ажилласан хугацааг хуанлийн жилээр тооцох бөгөөд дээр дурдсан ажлуудаас чөлөөлөгдөх шалгалт нь адилхан, 2-оос дээш ажилд ажилласан этгээдийн хувьд тус тусын ажилласан хугацааг 10 жилээр шилжүүлэн бодож 1 жилийн үнэлгээг гаргаад улмаар нийт ажилласан жилийг тооцож гаргахад 10-аас дээш гарч байх юм бол уг этгээдийг хүсэлтийнх нь дагуу тухайн шалгалтаас чөлөөлнө.

Тус зүйлд заасны дагуу шалгалтаас чөлөөлөгдөх этгээд нь шалгалт өгөх өргөдөлдөө шалгалтаас чөлөөлөгдөх эрхтэй гэдгээ батлах бичиг баримтыг хавсаргана. Бүх шалгалтаас чөлөөлөгдөх болсон этгээд нь ТМНБ-ийн шалгалтаас чөлөөлж өгөх тухай өргөдөлдөө шалгалтаас чөлөөлөгдөх эрхтэй болохыг батлах бичиг баримтыг хавсарган ирүүлснээр шалгалтаас чөлөөлөгдөнө.

*Есдүгээр зүйл
Шалгалт явуулах тухай дүрэм*

Тайлбар

ТМНБ-ийн шалгалтыг авч явуулах дараалал, түүнтэй холбогдолтой бусад тодорхой зүйлсийг мэргэжлийн зөвлөл шийдэх бөгөөд тухайн шийдвэрийг ҮТЕГ-ын даргаар батлуулна.

ТМНБ-ийн шалгалтыг жилд нэг удаа явуулах бөгөөд ҮТЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гадаад оронд ч явуулж болно.

*Аравдугаар зүйл
Шалгалтын дүнг хүчингүй болгох тухай*

Тайлбар

" *Шударга бус аргаар* " гэдэг нь шалгалт өгөх эрхгүй мөртлөө шалгалтанд орох буюу өөр этгээдээр шалгалтаа өгүүлэх, ашиглаж үл болох ном материал ашиглах, бусад шалгалт өгөгчийн хариултыг хуулах зэрэг үйлдлийг хэлнэ.

Мэргэжлийн зөвлөлөөс ийм хэрэг үйлдсэн этгээдийг шалгалт өгөхийг нь болиулах бөгөөд хэрэв шалгалт өгсний дараа ийм хэрэг үйлдсэн нь илрэх юм бол шалгалтын дүнг хүчингүй болгоно. Мөн иймэрхүү хэрэг үйлдсэн этгээдийг хэргийнх нь нөхцөл байдлаас нь хамааруулан 3 жил хүртэлх хугацаагаар ТМНБ-ийн шалгалт өгөх эрхийг нь хасна..

*Арван нэгдүгээр зүйл
Шалгалтанд тэнцсэн тухай үнэмлэх олгох тухай*

Тайлбар

" *ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн этгээд* " гэдэг нь ТМНБ-ийн бүх шалгалтанд тэнцсэн этгээдийг хэлнэ. Мөн зарим шалгалтаас чөлөөлөгдөж, бусад шалгалтан дээрээ тэнцсэн бол тус этгээдийг шалгалтанд тэнцсэн гэж үзнэ. Зарим шалгалтанд тэнцэж, бусад үлдсэн шалгалтаас чөлөөлөгдсөн тохиолдолд тус этгээдийг ТМНБ болох эрхтэй гэж үзэх боловч ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн этгээд гэж үзэхгүй.

Зарим шалгалтанд тэнцсэн этгээдэд ТМНБ-ийн зарим шалгалтанд тэнцсэн тухай мэдэгдэх хуудас илгээнэ.

*Арван хоёрдугаар зүйл
Шалгалтын тухай бусад тодорхой зүйл*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-ийн шалгалт өгөхтэй холбогдсон бусад тодорхой зүйлсийг мэргэжлийн зөвлөл батлах тухай заасан. Тодорхой хэлбэл, ТМНБ-ийн шалгалт явуулах өдөр цаг, газар, шалгалт өгөх өргөдөл

хүлээн авах хугацаа болон шалгалт өгөхтэй холбогдсон бусад зүйлийг мэргэжлийн зөвлөл шийдвэрлэнэ.

ТМНБ-ийн шалгалт өгөх этгээд болон ТМНБ-ийн зарим шалгалтаас чөлөөлөгдөх этгээд нь мэргэжлийн зөвлөлөөс баталсан шалгалт өгөх, шалгалтаас чөлөөлөгдөх тухай өргөдөл гаргана.

*Гуравдугаар бүлэг
Бүртгүүлэх тухай*

*Арван гуравдугаар зүйл
Бүртгэл явуулах тухай*

Тайлбар

ТМНБ болох эрх бүхий этгээд нь ТМНБ-оор бүртгүүлснээр сая ТМНБ болно. Ийм ч учраас ТМНБ болох эрхтэй хэдий ч бүртгэл хийлгээгүй бол ТМНБ гэж тооцохгүй болно.

ТМНБ болох эрх бүхий этгээд гэдэг нь тус хуулийн 3-р зүйлд заасан этгээд бөгөөд тус хуулийн 4-р зүйлд заах ТМНБ болох эрхийн чадваргүй тухай заалтад хамаарахгүй болно.

ТМНБ-оор бүртгүүлэх этгээд нь бүртгүүлэх тухай өргөдлөө мэргэжлийн зөвлөлд гаргана.

Бүртгүүлэх зүйл нь 1) Овог нэр

2) Төрсөн он, сар, өдөр

3) ТМНБ-ийн албан конторын нэр болон байршил

4) Иргэний харъяалал болон байнгын хаяг

5) ТМНБ болох эрх олж авсан хэлбэр болон уг эрхийг олж авсан он, сар, өдөр

6) ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад алба хашиж байсан этгээдийн хувьд тухайн ажлаас гарсан өдрөөс өмнөх 5 жилд хашиж байсан албан тушаалын нэр болон ажилласан хугацаа зэрэг болно.

*Арван дөрөвдүгээр зүйл
ТМНБ-дын нэрсийн жагсаалт*

Тайлбар

ТМНБ-дын нэрсийн жагсаалтыг мэргэжлийн зөвлөлөөс гаргана. ТМНБ-дын нэрсийн жагсаалтын бүртгэлийг мэргэжлийн зөвлөл хөтөлнө. Энэхүү нэрсийн жагсаалтын дагуу бүртгэл хөтлөх систем нь бүртгүүлсэн этгээдийг хянах урьдчилсан нөхцөл болж өгөх юм.

*Арван тавдугаар зүйл
Бүртгэлд өөрчлөлт хийлгэх тухай*

Тайлбар

ТМНБ-ийн нэрсийн жагсаалтанд бүртгүүлсэн зүйлд өөрчлөлт орсон тохиолдолд нэн даруй дахин бүртгүүлэхээр хандах хэрэгтэй. Бүртгэлд өөрчлөлт орж болох зүйл нь бүртгүүлэгчийн овог нэр, ТМНБ-ийн албан конторын нэр, байршил, харъяалал, хаяг, ТМНБ-ийн эрх олж авсан байдал зэрэгт болно. Бүртгэлд нь өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлт орсон зүйл болон өөрчлөлт орсон шалтгаан, өөрчлөлт орсон он, сар, өдөр болон бусад холбогдох зүйлийг бичиж тэмдэглэсэн өргөдлөө мэргэжлийн зөвлөлд нэн даруй гаргана.

*Арван зургадугаар зүйл
Бүртгүүлэхээр өргөдөл гаргах тухай*

Тайлбар

ТМНБ-ийн нэрсийн жагсаалтад бүртгүүлэхээр хандаж буй этгээд нь тус хуулийн 13-р зүйлд заасан бүртгүүлэх зүйл, боловсрол болон ажил байдлын тодорхойлолт, бусад холбогдох зүйлийг бичиж тэмдэглэсэн өргөдөлдөө ТМНБ болох эрх бүхий этгээд гэдгийг батлах бичиг баримтыг зургийн хамт хавсарган мэргэжлийн зөвлөлд ирүүлнэ. Мөн 15-р зүйлийн заалтын дагуу бүртгэлийн өөрчлөлт хийхтэй холбогдсон өргөдлийг ч бас мэргэжлийн зөвлөлд ирүүлнэ.

Өргөдөл гаргагч нь өргөдлөө эх, хуулбарын хамт 3 хувь ирүүлэх бөгөөд өргөдлийн эх загварыг мэргэжлийн зөвлөл тогтооно.

*Арван долдугаар зүйл
Бүртгэхийг зөвшөөрөх тухай*

Тайлбар

Мэргэжлийн зөвлөл нь өргөдөл гаргагчаас бүртгүүлэх өргөдөл ирсэн тохиолдолд тухайн өргөдөл гаргагч ТМНБ болох эрхтэй эсэх, бүртгэлд авахаас татгалзах ямар нэгэн шалтгаан бий эсэх (тус хуулийн 18-р зүйл)-ийг шалгаж, тухайн этгээд бүртгүүлэх эрхтэй, бүртгэлд авахад ямар нэгэн татгалзах шалтгаан байхгүй бол түүнийг бүртгэлд авна.

Тухайн этгээд эрхийн чадваргүй, аль эсхүл бүртгэхээс татгалзах шалтгаан буй нь тогтоогдвол тухайн этгээдийн бүртгүүлэх өргөдлийг хүлээн авахгүй.

Мэргэжлийн зөвлөл нь өргөдөл гаргагчийг ТМНБ-дын нэрсийн жагсаалтанд бүртгэсэн тохиолдолд тус өргөдөл гаргагчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр ТМНБ-ийн үнэмлэхийг биечлэн гардуулна.

Мэргэжлийн зөвлөл нь өргөдөл гаргагчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд бүртгэхээс татгалзах тухай болон түүний шалтгааныг тус этгээдэд бичгээр мэдэгдэнэ. Өргөдөл гаргагч этгээд бүртгэлд авах

эрхтэй холбогдсон чухал зүйл (ТМНБ болох эрх болон бүртгэхээс татгалзах шалтгаан)-ийг өргөдөлдөө бичээгүй, эсвэл худал зүйл бичсэнээс бүртгэлээс татгалзах шалтгаанд хамаарах болсон тохиолдолд бүртгэхээс татгалзах тухай мэдэгдэх хуудсанд энэ тухай тодорхой тэмдэглэх шаардлагатай. Ийм шалтгаанаар бүртгэлд авахаас татгалзах арга хэмжээ шийтгүүлсэн этгээд нь тус хуулийн 4-р зүйлийн 1 дэх хэсгийн 9-д заасны дагуу бүртгэхээс татгалзах арга хэмжээ шийтгэгдсэн өдрөөс 3 хүртэлх жилийн хугацаанд ТМНБ болох эрхгүй болох тул уг арга хэмжээ авах үндэслэлийг тодорхой болгох үүднээс дээрх шалтгааныг бичих шаардлагатай.

*Арван наймдугаар зүйл
Бүртгэхээс татгалзах үндэслэл*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-ийг бүртгэхээс татгалзах үндэслэлийн тухай заасан бөгөөд ТМНБ болох эрхтэй хэдий ч доор заасан бүртгэхээс татгалзах шалтгаанд хамаарах тохиолдолд тухайн этгээд нь ТМНБ-оор бүртгүүлэх боломжгүй юм.

ТМНБ-оор бүртгэхээс татгалзах үндэслэлд хамаарах этгээд гэдэгт

- 1) ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулахад тэнцэхгүй этгээд (Доор дурдах (1) болон (3)-аас (8) хүртэлх дугаарт хамаарах этгээд)
- 2) Төрийн алба хашиж буйн улмаас тухайн хугацаанд ТМНБ-ийн ажил эрхлэхэд тохиромжгүй этгээд ((2)) энэ 2 этгээд хамаарна.

(1) Сахилгын арга хэмжээнд буй этгээд

Сахилгын арга хэмжээ шийтгүүлж, мэргэжсэн нягтлан бодогч, өмгөөлөгчийн ажлаа зогсоох арга хэмжээнд буй этгээд, мөн ТМНБ-оор бүртгүүлээд ТМНБ болсныхоо дараа ажил эрхлэхээ зогсоох сахилгын арга хэмжээ шийтгэгдсэн тохиолдолд тус хугацаанд ТМНБ-ийн ажил эрхэлж үл болно. (Тус хуулийн 39-р зүйл)

(2) Төрд алба хашиж буй этгээд

Ажлын хөлс урамшуулал бүхий төрийн албаны ажил хашиж буй этгээд нь (УИХ болон орон нутгийн ИТХ-ын гишүүний алба хашиж буй этгээд болон орон тооны бус ажилтан үүнд хамаарахгүй болно.) ТМНБ-оор бүртгүүлж үл болно.

" Ажлын хөлс урамшуулал бүхий төрийн албаны ажил" гэдэг нь УИХ, шүүх, төрийн засаг захиргааны байгууллага болон олон нийтийн байгууллага дахь албыг хэлнэ. " Ажлын хөлс урамшуулал " гэдэг нь тодорхой алба ажил хийсний хөлсөнд олгох олговрыг хэлэх бөгөөд үүнд нөхөн олговор орохгүй болно.

(3) Татвараас зайлсхийх үйлдэл үйлдээд 5 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй этгээд

Шударга бусаар татвар ногдуулалт, татвар хураалтаас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан, зайлсхийх боломж олгосон болон зайлсхийх боломж олгохыг завдсан үйлдэл үйлдсэн өдрөөс 5 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй этгээдийг хэлнэ.

Энд өгүүлэх "татвар" гэдэгт гаалийн татвар ч мөн адил хамаарна. Торгох ял болон хорих ялаас дээш хэмжээний ял шийтгэгдээгүй боловч татвар ногдуулалт, татвар хураалтаас зайлсхийсний улмаас бага хэмжээний торгууль тавигдсан буюу энэ талаар шүүхэд нэхэмжлэл гарсан боловч хэргийг хойшлуулсан буюу хэргийг шүүхийн журмаар авч хэлэлцэх шаардлагагүй болсон, мөн энэ талаар нэхэмжлэл гараагүй боловч татвар нэмж төлөх шийтгэл шийтгэгдсэн бол энэ нь "зайлсхийсэн"–д хамаарна. Татвараас зайлсхийхээр зэхэж байсан болон зайлсхийх үйлдэл бодитойгоор явуулах гэж байсан, зайлсхийхээр хэлцэж байсан тохиолдолд "зайлсхийхийг завдсан"–д хамаарна. Харин бусдыг хатгах болон туслах замаар татвараас зайлсхийх боломж олгосон болон боломж олгох гэсэн тохиолдолд "зайлсхийх боломж олгосон" болон "зайлсхийх боломж олгохыг завдсан" гэдэгт хамаарна.

"Гэмт үйлдэл болсон өдөр" гэдэг нь тухайн гэмт хэргийг шүүх хүлээн зөвшөөрсөн өдрийг, хэрэв шүүх дээр хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд цагдаагийн байгууллагын тогтоосон өдрийг, дээр дурдсанаас бусад тохиолдолд ҮТЕГ–ын дарга, аймаг нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс болон гаалийн албаны дарга (орон нутгийн албан татварын хувьд орон нутгийн олон нийтийн байгууллагын дарга)–ын тухайн гэмт үйлдлийг хүлээн зөвшөөрсөн өдрийг хэлнэ. Доор дурдах (4), (5)–ын хувьд ч мөн адил.

(4) Хууль бусаар татвар буцаан авсан үйлдэл үйлдсэн өдрөөс 5 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй этгээд

Татвараа хууль бусаар буцаан авсан болон буцаан авахыг завдсан, эсвэл буцаан авах боломж олгосон болон боломж олгох гэсэн үйлдэл үйлдсэн өдрөөс 5 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй этгээд

(5) Улс, орон нутгийн татвар болон нягтлан бодох бүртгэлийн талаар эрүүгийн хуулийн эсрэг үйлдэл хийсэн этгээд

Энэ нь татвар болон нягтлан бодох бүртгэлийн ажлын талаар эрүүгийн хуулийн эсрэг үйлдэл хийгээд уг өдрөөс 5 хүртэлх жилийн

хугацаа өнгөрөөгүй этгээд юм.

"Татвар болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой ажил" гэдэгт засаг захиргааны байгууллага болон пүүс компани дахь татвар суутган тооцох ажил болон нягтлан бодох бүртгэл зэрэг ажил хамаарна. "Эрүүгийн хуулийн эсрэг үйлдэл" гэдэгт ТМНБ, мэргэжсэн нягтлан бодогч, өмгөөлөгчийн хуулинд заасан гэмт хэрэгт хамаарах үйлдлээс гадна тухайлбал, хураан авсан татварыг хувьдаа ашиглах, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдэх үйлдэл ч үүнд хамаарна. Иймээс ийм үйлдэл үйлдсэн этгээдийг тухайн үйлдэл хийсэн өдрөөс 5 хүртэлх жилийн хугацаанд ТМНБ-оор бүртгэхээс татгалзах шалтгаанд хамааруулан шийтгэнэ.

Гэхдээ энд эрүүгийн хуулийн эсрэг үйлдэл хийсэн хэдий ч ял шийтгэл шийтгэгдээгүй этгээдийн тухай өгүүлж байгаа бөгөөд хэрвээ ял шийтгэл шийтгүүлсэн тохиолдолд мэдээж тухайн этгээд нь ТМНБ болох эрхгүй (Тус хуулийн 4-р зүйл) гэсэн заалтад хамаарах тул тухайн ялыг эдэлж дуусаад болон тухайн ялыг эдлэхгүй болсон өдрөөс эхлэн тодорхой хугацаанд ТМНБ болох эрхгүй болно.

(6) Бие, сэтгэл санааны эмгэгтэй этгээд

Бие, сэтгэл санааны эмгэгтэйн улмаас ТМНБ-ийн ажилд тэнцэхгүй этгээдийг хэлнэ. Хэдийгээр бие, сэтгэл санааны эмгэгтэй хэдий ч ТМНБ-ийн ажилд тэнцэхгүй гэсэн ямар нэгэн эргэлзээ байхгүй тохиолдолд энэ нь бүртгэхээс татгалзах шалтгаан болохгүй.

"Тэнцэхгүй гэсэн эргэлзээ" гэдэг нь бие, сэтгэл санааны эмгэгийн улмаас ТМНБ-ийн хүлээсэн ажлын үүрэг хариуцлагыг биелүүлж чадахгүй, ТМНБ-ийн ажлыг зохих ёсоор явуулж чадахгүй этгээдийг хэлнэ.

(7) ТМНБ-д тэнцэхгүй этгээд

ТМНБ-ийн итгэл найдвар, нэр хүндийг хөсөрдүүлэх аюултай, ТМНБ-ийн хүлээсэн ажлын үүрэг хариуцлагын хувьд ТМНБ-д тэнцэхгүй этгээдийг хэлнэ.

ТМНБ нь хүлээсэн үүрэг хариуцлагынхаа дагуу татвар төлөгчийн итгэлийг хүлээн татвар төлүүлэх үүргийг зохих ёсоор биелүүлэхийг эрхэм зорилго болгодог бөгөөд уг зорилгоо биелүүлэхийн тулд өөрийн нэр хүндийг сахин хамгаалж, татвар төлөгчийн итгэлийг олох хэрэгтэй болно. ТМНБ нь өөрийн нэр хүндийг өндөрт өргөн явж, бусдын итгэлийг олох явдал нэн чухал бөгөөд үүнийг биелүүлж чадахгүй этгээд болон ТМНБ-ийн ажлын үүрэг хариуцлагын хувьд ТМНБ-д тэнцэхгүй этгээд нь бүртгэхээс татгалзах шалтгааны заалтад хамаарна.

(8) Бүртгэлийн хураамжаа бүрэн төлөөгүй этгээд ТМНБ-ийн бүртгэлийн хураамжаа төлөөгүй этгээдийг мэдээж бүртгэхээс татгалзана.

*Арван есдүгээр зүйл
Бүртгэлийг хүчингүй болгох тухай*

Тайлбар

Тус зүйлийн 1 дэх хэсэг нь хуурамч тэмдэглэгээ бүхий өргөдөл гаргаж, мэргэжлийн зөвлөлд ТМНБ-оор бүртгүүлсэн ТМНБ-ийн үйлдэл илэрсэн тохиолдолд тухайн бүртгэлийг хүчингүй болгохтой холбогдсон заалт юм. Өөрөөр хэлбэл, өргөдөл гаргагч нь ТМНБ болох эрх болон тус зүйлийн 18-р зүйлд заасан бүртгэхээс татгалзах шалтгаанд холбогдох зүйлийг бичээгүй, эсвэл худал тэмдэглэгээ бүхий өргөдөл гаргасан нь бүртгэл явуулахаас өмнө тогтоогдсон тохиолдолд тухайн өргөдлийг мэргэжлийн зөвлөл хүлээн авахгүй (Тус хуулийн 17-р зүйл) бөгөөд тухайн өргөдлийг хүлээж авахаас татгалзсан өдрөөс 3 хүртэлх жилийн хугацаанд тухайн этгээдэд ТМНБ болох эрх олгохгүй (Тус хуулийн 4-р зүйл). Харин тус өргөдлийн дагуу нэгэнт бүртгэчихсэн тохиолдолд мэргэжлийн зөвлөл нь тус зүйлд заасны дагуу бүртгэлийг хүчингүй болгох бөгөөд тус арга хэмжээ шийтгэгдсэн өдрөөс 3 хүртэлх жилийн хугацаанд тухайн этгээдэд ТМНБ болох эрх олгохгүй (Тус хуулийн 4-р зүйл).

2-р хэсэгт ТМНБ-оор бүртгүүлсэн ТМНБ өөрөө болон татвар төлөгчийг ашиглан үйлдсэн татварын тайлан мэдээ зэрэг татварын холбогдолтой аливаа үйлдэл нь олон нийтийн эсрэг чиглэсэн гэдэг нь тогтоогдсон тохиолдолд мэргэжлийн зөвлөл тухайн ТМНБ-ийн бүртгэлийг хүчингүй болгох тухай заасан.

"Өөрөө болон татвар төлөгчийг ашиглан" гэдэг нь ТМНБ, түүний хөлслөн ажиллуулж буй этгээд өөрсдөө буюу татвар төлөгчийг ашиглан эсвэл өдөөн хатгах зэргээр олон нийтийн эрх ашигт харшилсан татварын холбогдолтой үйлдэл үйлдэхийг хэлнэ.

"Тайлан мэдээ гэх зэрэг татварын холбогдолтой аливаа үйлдэл" гэдэг нь татвартай холбоотой бүх зүйл, үйлдлийг хэлж буй бөгөөд үүнд шууд буюу дам холбоотой бүх зүйл хамаарна.

"Олон нийтийн эрх ашгийг хөндсөн үйлдэл үйлдсэн нь хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдол" гэдэг нь үүрэгт ажлаа цалгардуулснаас бусад татвар төлөгчид муугаар нөлөөлсөн болон ҮТЕГ буюу бусад шатны татварын байгууллагын үйл ажиллагаа явуулахад ихээхэн хохирол учруулах магадлал ихтэй гэж үзсэн тохиолдлыг хэлж буй бөгөөд үүнийг мэргэжлийн зөвлөл тогтоох тухай тодорхой заасан.

3-р хэсэгт ТМНБ-оор бүртгүүлсэн этгээд нь бүртгэлийн хураамжаа төлөөгүй буюу давтан сургалтанд 2 удаа хамрагдаагүй тохиолдолд мэргэжлийн зөвлөл тухайн этгээдийн бүртгэлийг хүчингүй болгох тухай заасан. Мэдээжийн хэрэг ТМНБ болох эрхтэй этгээд нь ТМНБ-оор бүртгүүлснээр сая ТМНБ болж чадах бөгөөд мэргэжилтний энэ эрхээ хадгалах үүднээс мэргэжлийн зөвлөлийн тогоосноор дахин бүртгүүлж байх шаардлагатай. Энэхүү дахин бүртгэл хийлгэхэд бүртгэл баталгаажуулах хураамж төлж, бүртгэл баталгаажуулах сургалтанд хамрагдах үүрэг ТМНБ-д ногддог. Иймээс ч энэхүү хураамжаа төлөөгүй болон бүртгэл баталгаажуулах сургалтанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 удаа суугаагүй этгээдийн бүртгэлийг хүчингүй болгох тухай заасан. Энэхүү хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт өвдөж бэртсэний улмаас сургалтанд хамрагдаж чадахгүй болох зэрэг тодорхой шалтгаан л хамаарна.

Тус зүйлийн 1-р хэсгээс 3-р хэсэгт заасны дагуу мэргэжлийн зөвлөл нь ТМНБ-ийн бүртгэлийг хүчингүй болгох тохиолдолд бүртгэл хүчингүй болгох тухай болон тус шалтгаанаа тухайн шийтгэл хүлээх этгээдэд болон ҮТЕГ-т бичгээр мэдэгдэх шаардлагатай. Энэхүү мэдэгдэх хуудсыг тухайн шийтгэл хүлээх этгээдэд ТМНБ-ийн нэрсийн жагсаалтан дахь хаягаар илгээхэд л хангалттай.

*Хорьдугаар зүйл
Бүртгэлээс хасах тухай*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-ийн бүртгэлээс хасах тухай заасан бөгөөд ТМНБ-ийн эрх нь зөвхөн тухайн этгээдэд л хадгалагдах зүйл тул түүнийг өвлүүлэх юмуу бусдад шилжүүлж болохгүй.

(1) ТМНБ-ийн ажил эрхлэхээ больсон тохиолдолд

ТМНБ нь ажлаа эрхлэхээ больсон тохиолдолд ТМНБ байх шаардлагагүй тул ТМНБ-ийн нэрсийн жагсаалтыг цэгцлэх үүднээс мэргэжлийн зөвлөл нь тухайн этгээдийг бүртгэлээс хасна. ТМНБ ажлаа эрхлэхээ больсон тохиолдолд тухайн этгээд өөрөө болон түүний төлөөний хүн нь мэргэжлийн зөвлөлд ТМНБ-ийн ажлаа эрхлэхээ больсон тухай бичгээр мэдэгдэнэ (Тус мэдэгдэх хуудсыг шуудангаар илгээсэн ч болно.). Энэхүү мэдэгдэх хуудсыг хүлээн авсан мэргэжлийн зөвлөл нь нэн даруй тус ТМНБ-ийг бүртгэлээс хасах ажлыг явуулах бөгөөд энэ тохиолдолд ТМНБ гэсэн албан тушаал нь (ТМНБ болох нь) тухайн этгээд бүртгэлээс хасагдах хүртэл хэвээр хадгалагдана.

(2) Нас барсан тохиолдолд

Насбарсан тохиолдолд ТМНБ-ийн эрх үгүй болох бөгөөд тухайн этгээдийг бүртгэлээс хасах нь зөвхөн ТМНБ-дын нэрсийн жагсаалтыг цэгцэлж буй хэрэг юм.

(3) Бүртгэл хүчингүй болгох арга хэмжээ шийтгүүлсэн тохиолдолд

19-р зүйлд ТМНБ-оор бүртгүүлсэн этгээд нь мэргэжлийн зөвлөлөөс бүртгэл хүчингүй болгох арга хэмжээ шийтгүүлсэн тохиолдолд ТМНБ-ийн эрхээ алдах ба ТМНБ-ийг бүртгэлээс хасах ажил нь бичиг цаас цэгцлэх ажлаар дуусна.

(4) ТМНБ болох эрхгүй тухай заалтад хамаарах болсон тохиолдолд

ТМНБ нь тус хуулийн дээрх заалтад хамаарах болсон тохиолдолд, мөн тус хуулийн 4-р зүйлийн 2-оос 9 хүртэлх дугааруудад заах эрхийн чадваргүй тухай заалтад хамаарах болсон тохиолдолд, ТМНБ-ийн эрхээ ямар нэгэн шалтгаанаар алдсан тохиолдолд ТМНБ-ийн эрх нь алдагдах бөгөөд үүний дараа тухайн этгээдийг бүртгэлээс хасах бичиг хэргийн ажил явагдана.

Тус зүйлийн 3-аас бусад хэсгийн заалтын аль нэгт хамаарах болсон тохиолдолд тус этгээд, түүний хууль ёсны төлөөний этгээд болон өв залгамжлагч нь энэ талаар Монголын ТМНБ-дын холбоонд мэдэгдэнэ.

Хорин нэгдүгээр зүйл

Бүртгэлд авсан болон бүртгэлээс хассан тухай олон нийтэд мэдээлэх нь

Тайлбар

ТМНБ нь татвар төлөгчтэй нягт холбоотой ажилладаг бөгөөд ТМНБ-ийн ажил нь татвар төлөгч болон ТМНБ хоёрын итгэлцэл дээр тулгуурлаж байдаг тул ТМНБ-ийн бүртгэлийг явуулахдаа шударга байр сууринаас хандах хэрэгтэй.

Иймд мэргэжлийн зөвлөл нь ТМНБ-ийг бүртгэх болон бүртгэлээс хасахдаа нэн даруй тэр тухай, бүртгэлээс хассан тохиолдолд уг шалтгааны талаар (Жишээлбэл, ажлаа эрхлэхээ больсон болон нас барсны улмаас гэдгийг нарийн заан) олон нийтэд мэдээлэх хэрэгтэй.

Хорин хоёрдугаар зүйл

ТМНБ-ийн үнэмлэхийг буцаах тухай

Тайлбар

ТМНБ-ийн үнэмлэхийг ТМНБ-оор бүртгүүлэхэд олгох бөгөөд (Тус хуулийн 17-р зүйл), ТМНБ нь үнэмлэхээ татварын үйл ажиллагаа

төлөөлөн явуулахаар татварын байгууллагын ажилтантай уулзах үедээ үзүүлнэ (Тус хуулийн 26–р зүйл) .

ТМНБ–ийн үнэмлэх нь ийнхүү тухайн этгээдийг ТМНБ–оор бүртгүүлснийг олон нийтэд баталж өгөх зүйл тул ТМНБ–ийн бүртгэлээс хасагдсан тохиолдолд тус этгээд болон түүний хууль ёсны төлөөний этгээд, аль эсхүл өв залгамжлагч нь тус ТМНБ–ийн үнэмлэхийг буцаан олгоно.

ТМНБ нь ажлын хөлс урамшуулал бүхий төр, олон нийтийн байгууллага (УИХ, орон нутгийн ИТХ –ын гишүүний ажил болон орон тооны бус ажил үүнд үл хамаарна)–д алба хашиж буй хугацаандаа ТМНБ–ийн ажил явуулж болохгүй (Тус хуулийн 37–р зүйл) бөгөөд мөн мэргэжсэн нягтлан бодогч болон өмгөөлөгчийн ажил эрхлэхийг хориглох болон зогсоох сахилгын арга хэмжээ шийтгүүлсэн тохиолдолд уг арга хэмжээ шийтгэгдэж буй үедээ ТМНБ–ийн ажил эрхэлж үл болох тул (Тус хуулийн 37–р зүйл) эдгээр тохиолдолд тус этгээд болон түүний хууль ёсны төлөөлөгч нь ТМНБ–ийн үнэмлэхийг буцаан олгох шаардлагатай.

ТМНБ–ийн ажил эрхлэхийг хориглох болон зогсоох сахилгын арга хэмжээ шийтгэгдсэн тохиолдолд (Хуулийн 39–р зүйл болон 40–р зүйл) ч нэгэн адил ТМНБ–ийн үнэмлэхийг мэргэжлийн зөвлөлд буцаан өгнө.

ТМНБ–ийн ажил эрхлэхээ түр хугацаагаар зогсоох болох хориглох арга хэмжээ шийтгэгдсэн этгээд ТМНБ–ийн ажил дахин эрхлэх болсон тохиолдолд түүний өргөдлийн дагуу ТМНБ–ийн үнэмлэх тухайн этгээдэд дахин олгогдоно.

Дөрөвдүгээр бүлэг

ТМНБ–ийн бүртгэл баталгаажуулах тухай

Хорин гуравугаар зүйл

ТМНБ–ийн бүртгэл баталгаажуулах тухай

Тайлбар

Тус зүйлд ТМНБ–ийн эрх олж авахад дээд зэргийн мэргэжлийн чадвар шаардлагатай тул ТМНБ–оор бүртгүүлсэн этгээд нь мэргэжлийн зөвлөлөөс зохион байгуулах давтан сургалтанд жилд нэг удаа хамрагдах үүрэгтэй тухай заасан. Энэхүү давтан сургалтанд хоёр дараалан хамрагдаагүй болон бүртгэл баталгаажуулах хураамжаа мэргэжлийн зөвлөлд төлөөгүй ТМНБ–ийн бүртгэлийг мэргэжлийн зөвлөл хүчингүй болгоно (Тус хуулийн 19–ийн ③).

*Тавдугаар бүлэг
ТМНБ-ийн эрх үүрэг*

*Хорин дөрөвдүгээр зүйл
Татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулах бүрэн эрхтэй гэдгээ
мэдэгдэх тухай*

Тайлбар

ТМНБ нь татварын холбогдолтой үйл ажиллагаа төлөөлөн явуулахдаа тус үйл ажиллагаа явуулах эрхтэй гэдгийг батлах бичиг баримтыг ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад гаргана. ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллага нь татвар ногдуулалт, татвар хураалт болон бусад үйл ажиллагаа явуулахад ТМНБ-ийн харилцагч этгээд болох тул ТМНБ-ийн төлөөлөн болон орлон явуулах татварын үйл ажиллагаа нь зохих эрхийн үндсэн дээр явагдах ёстой нь мэдээжийн хэрэг юм. Иймээс ажил хэргийн харилцагч этгээд болох ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад үүнийгээ илэрхийлэхийн тулд өөрийн явуулж буй үйл ажиллагаа нь зохих эрхийн үндсэн дээр явагдаж буй гэдгээ батлах зүйлийг үзүүлэх шаардлагатай. Энэхүү баталгаа болгож ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулах эрхтэй гэдгийг батлах бичиг баримтыг гаргах хэрэгтэй.

ТМНБ нь "Татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулах тохиолдолд" тус эрхтэй гэдгээ батлах бичиг баримтыг гаргах ёстой тухай заасан хэдий ч энд өгүүлэх "Татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулах" гэдэг нь 1-д заасан үйл ажиллагааг хэлж буй юм. 1-д заасан үйл ажиллагаа мөн эсэхийг ажил итгэмжлэн хийлгүүлж буй этгээд, ажил итгэмжлэгдэн хийж буй этгээд, ажил хэргийн харилцагч этгээд болох ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллага, үйл ажиллагаанн объект таарч буй эсэхээр тогтооно. Энэ тохиолдолд 2-р зүйлийн 1-д заасан тайлан, өргөдөл, нэхэмжлэл, гомдол зэрэг нь тус тус ялгаатай үйл ажиллагаа бөгөөд энэ нь үүнийг тогтооход тодорхой хэмжүүр болж өгөх болов уу.

Татварын холбогдолтой үйл ажиллагааг төлөөлөн явуулах эрхтэй гэдгээ батлах бичиг баримтыг тушаах хугацаа нь үндсэндээ үйл ажиллагааг төлөөлөн болон орлон явуулж эхлэх үед юм. Ихэнх тохиолдолд тайлан мэдээ болон өргөдөл хүсэлт гаргах зэрэг үйл ажиллагааг төлөөлөн явуулахад гаргах бичиг баримтандаа хавсарган гаргана. Гэхдээ онцгой тохиолдол биш л бол заавал ч үгүй анхны үйл ажиллагааны үед гаргана гэсэн хэрэг биш, бас зарим тохиолдолд үйл ажиллагааны дунд шатанд болон сүүлийн шатанд гаргасан ч болно.

Бичиг баримтаа зөвхөн ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад гаргах тухай тус зүйлд заасан. Бичиг баримтдаа ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагын хаягийг бичих албагүй

бөгөөд тухайн бичиг баримтыг холбогдох эрх бүхий татварын байгууллагын ажилтан хүлээн авахад л болно.

Бичиг баримтыг тушаагаагүй тохиолдолд ч татварын төлөөлөн болон орлон явуулах үйл ажиллагаа урьдын хэвээр явагдах бөгөөд бичиг баримт тушаах үүргээ биелүүлээгүй ТМНБ нь зохих хариуцлага хүлээх нь тодорхой.

*Хорин тавдугаар зүйл
Тусгай зөвшөөрөл авах тухай*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ нь татварын холбогдолтой үйл ажиллагаа төлөөлөн явуулахдаа нэн ялангуяа татвар төлөгчийн эрх ашгийг хөндсөн зүйл байх юм бол энэ нь ердийн нэг татварын төлөөлөх эсвэл орлох үйл ажиллагаа явуулах эрхээс ондоо зүйл тул тусгай зөвшөөрөл авах хэрэгтэй тухай заасан .

Тиймээс ТМНБ нь татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулахдаа тус эрхтэй болохоо баталсан бичиг баримтыг ҮТЕГ болон бусад татварын байгууллагад гаргахгүй хэрэгтэй бөгөөд ялангуяа энд дурдах үйл ажиллагаа явуулахдаа тусгай зөвшөөрөл авсан тухайгаа гэрчлэх бичиг баримтыг тусгайд нь гаргах хэрэгтэй болно.

Татварын холбогдолтой үйл ажиллагааг төлөөлөн болон орлон явуулах эрхтэй гэдгийг батлах бичиг баримтын загварыг хязгаарлан заагаагүй боловч энд дурдсан зүйлийн талаар тусгай зөвшөөрөл аван татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулах тохиолдолд гаргах бичиг баримт нь итгэмжлэх бичгийн хэлбэртэй байх хэрэгтэй.

Мөн тус зүйлд дурдах *"үйл ажиллагаа явуулах төлөөний этгээдийг сонгох"* гэдэг нь тухайн этгээдийн итгэмжлэгдсэн ТМНБ нь бас өөрийн төлөөний этгээдийг сонгохыг хэлэх бөгөөд өөрөөр хэлбэл, давхар итгэмжлэгдсэн төлөөлөгч сонгоно гэсэн үг юм. Татварын ажил итгэмжлэн хийлгүүлж буй этгээд, ТМНБ хоёрын хоорондын харилцаа нь тэдний харилцан итгэлцэл дээр тулгуурлаж байдаг тул ажил итгэмжлэн хийлгэгч этгээдийн таньж мэдэхгүй гуравдагч этгээдийг давхар итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж, улмаар тус этгээдийн төлөөлөн болон орлон явуулах татварын үйл ажиллагааны үр дүн нь уг этгээдэд буцаж ирнэ гэдгээс үзвэл энд итгэл хүлээлгэх тухай асуудал гарч ирнэ. Иймээс итгэмжлэгдсэн төлөөлөгчийг давхар сонгохдоо ажил итгэмжлэн хийлгүүлж буй этгээдээс тусгай итгэмжлэл, зөвшөөрөл авах хэрэгтэй болно.

Энэхүү давхар итгэмжлэгдсэн төлөөлөгчийн явуулах үйл ажиллагаа нь ТМНБ-ийн эрхлэх үйл ажиллагааны хүрээний ажил байх тохиолдолд тус давхар итгэмжлэгдсэн этгээд нь ч бас ТМНБ байх

шаардлагатай болно.

*Хорин зургадугаар зүйл
ТМНБ-ийн үнэмлэх үзүүлэх тухай*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ нь татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулахаар татварын байгууллагын ажилтантай уулзах үедээ ТМНБ гэдгээ батлах үнэмлэхийг үзүүлэх үүрэгтэй тухай заасан . Өмнөх 2 зүйлийн заалтын дагуу ТМНБ нь татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулах зохих эрхтэй гэдгээ батлах бичиг баримтыг гаргах нь ТМНБ-ийн эрх бүхий этгээд татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулах хуульд заасан эрхийнхээ дагуу тус үйл ажиллагааг явуулж буй гэдгийг баталж өгч байгаа хэрэг юм.

"Татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулах" гэдэг нь 27-р зүйлд заасан "татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулах" гэдэгтэй адилхан утгатай болно. ТМНБ нь татварын ажилтантай уулзаж, татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулахдаа тус ажилтныг шаардаагүй тохиолдолд ч гэсэн ТМНБ болохыг нь батлах ТМНБ-ийн үнэмлэхийг үзүүлнэ. Гэхдээ уг ТМНБ-ийн үнэмлэхийг үзүүлэх нь ТМНБ-ийн үүрэг тул татварын байгууллагын ажилтан нь хэрвээ ТМНБ үнэмлэхээ үзүүлээгүй бол уулзаж болохгүй гэсэн үг биш юм.

Мөн уг заалт нь 67-р зүйлд заасан ТМНБ биш этгээд нь ТМНБ-ийн ажил эрхэлж үл болно гэсэн санааг баталсан болно.

*Хорин долдугаар зүйл
Гарын үсэг зурах үүрэг*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулж, татварын холбогдолтой баримт бичиг боловсруулахад хүлээх хариуцлагыг тодорхой болгохын тулд ТМНБ нь боловсруулсан баримт бичигтээ өөрийн гарын үсгийг зурах тухай заасан.

ТМНБ нь татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулж, татварын холбогдолтой тайлан, өргөдөл, нэхэмжлэл боловсруулан, ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад гаргахдаа тухайн үйл ажиллагааг төлөөлөн явуулсан хүнийхээ хувьд өөрийн гарын үсгийг зурна.

Тухайн баримт бичиг нь татварын тайлан, татвар буцаан олголт хийх нэхэмжлэлтэй холбоотой бичиг баримт байх тохиолдолд тэрхүү тайлан, бичиг баримтад ТМНБ өөрийн гарын үсгийг зурахаас гадна тухайн этгээд ч мөн адил гарын үсэг зурна.

Ингэж ТМНБ-оос гадна тухайн этгээд ч бас өөрийн гарын үсгийг зурж буйн учир нь эдгээр бичиг баримт нь татвар төлөх үүргийг

тодорхой гаргасан, татвар буцаан олголт нэхэмжилсэн зэрэг тухайн татвар төлөгч этгээд болон татварын байгууллагын хувьд тун чухал бичиг баримт болох тул тус этгээд ч бас эдгээр баримт бичгийг яаж боловсруулсан талаар болон тус баримт бичгийн утга агуулгыг сайтар мэдэж байх хэрэгтэй бөгөөд татварын баримт бичгийг төлөөлөн боловсруулсан ТМНБ-ийн болон тухайн этгээдийн хүлээх хариуцлагыг тодорхой гаргаж өгөх шаардлагатай байдагтай холбоотой.

ТМНБ нь төлөөлөн явуулсан үйл ажиллагаатайгаа холбогдох баримт бичигт өөрийн гарын үсгийг зурахын зэрэгцээ татварын холбогдолтой баримт бичиг боловсруулахдаа ч бас тухайн баримт бичгийг боловсруулсан хариуцлагыг хүлээх тухайгаа илэрхийлэхийн тулд боловсруулсан баримт бичигтээ өөрийн гарын үсгийг зурна.

ТМНБ нь татварын холбогдолтой эдгээр үйл ажиллагааг төлөөлөн явуулахдаа болон хийж боловсруулсан татварын холбогдолтой баримт бичигт өөрийн гарын үсгийг зурахдаа ТМНБ болох тухайгаа бичнэ.

ТМНБ-ийн гарын үсэг зурсан эсэх нь нь тухайн бичиг баримтын хүчинтэй эсэхэд нөлөөлөхгүй. Иймээс ТМНБ-ийн гарын үсэг байхгүй гэдгээр уг баримт бичиг нь хүчингүй болохгүй.

*Хорин наймдугаар зүйл
Шалгалт хийх тухай мэдэгдэх*

Тайлбар

Тус зүйл нь ТМНБ-ийн үйл ажиллагаа төлөөлөн явуулах эрхийн тухай заалт юм. Энэхүү заалтад ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагын ажилтан татвар төлөгчид шалгалт явуулах үед энэ тухай үндсэндээ мэдэгдэх үүрэгтэй тухай заасан бөгөөд ингэснээр хариуцагч ТМНБ-д шалгалтанд оролцох эрх олгохын хамт ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагаас явуулах шалгалтыг үр дүнтэй явуулахыг зорилго болгосон болно. Гэхдээ энэхүү үүрэг хариуцлагын талаар хуулийн заалт байхгүй тул ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагын ажилтан энэхүү мэдэгдэл хийх үүргээ биелүүлээгүй байлаа ч энэхүү үүргийн биелэлттэй холбогдуулан татвар төлөгч болон ТМНБ нь тухайн ажилтантай хариуцлага тооцох боломжгүй юм. Тус зүйлд "үндсэндээ" мэдэгдэх үүрэгтэй гэж заасан тул энэ мэдэгдэх эсэх тухай асуудлыг ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллага өөрсдөө шийдэх асуудал юм. Тухайлбал, татвар төлөгч татвараас зайлсхийх үйлдэл хийхээр санаархаж байх үед татвар төлөгч болон ТМНБ-д шалгалт хийх тухай мэдэгдэх нь хэргийг илрүүлэхэд саад учруулж ч болох талтай тул ийм тохиолдолд татварын байгууллагын ажилтан нь урьдчилж мэдэгдэлгүйгээр шууд шалгалт явуулж эхлэх нь

зүйтэй. Ингэж энэ зүйлд татварын байгууллагын ажилтан нь татвар төлөгчид шууд шалгалт явуулахдаа үндсэндээ мэдэгдэх үүрэгтэй тухай заасан. Энэхүү заалтыг татварын албаны ажилтан зөрчлөө ч тухайн шалгалтын хүчинтэй эсэхэд нөлөөлөхгүй.

Энэхүү шалгалт явуулах тухай урьдчилан мэдэгдэхэд тавигдах ерөнхий шаардлага нь :

(1) Шалгалт явуулахын өмнө тухайн татвар төлөгч болон хариуцагч ТМНБ–д шалгалт явуулах өдөр, цаг, газар, шалгалт хийх татварын төрлийг мэдэгдсэний үндсэн дээр явуулах хэрэгтэй.

(2) Хариуцагч ТМНБ нь тухайн татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулах эрхтэй гэдгээ батлах бичиг баримтыг тушаасан байх ёстой. Шалгалт явуулах тухай мэдэгдэхдээ ам, бичиг, утасны аль ч хэлбэрийг сонгож болно. Гэхдээ шалгалт явагдахаас нэлээн өмнө мэдэгдэх хэрэгтэй бөгөөд шалгалтын яг өмнө утсаар мэдэгдэх төдийгөөр хэлбэрдэж болохгүй.

Шалгалт явуулах өдөр цаг, газар, шалгалт хийх татварын төрлийг мэдэгдэх бөгөөд үүнээс гадна шалгалтын зорилго зэргийг мэдэгдэх шаардлагагүй ч тэр тухай мэдэгдлээ гээд буруудах зүйлгүй.

Мэдэгдлийг хүлээн авсан ТМНБ нь итгэмжлэгдсэн төлөөлөгчийнхөө байр сууринаас шалгалтан дээр байлцаж санал бодлоо хэлж болно.

Энэхүү мэдэгдэл нь ТМНБ–ийг итгэмжлэгдсэн төлөөлөгчийнх нь хувьд хүндэлсэн хэрэг болохоос тухайн ТМНБ нь татварын үйл ажиллагааг төлөөлөн явуулах эрхтэй эсэхийг нь магадлах гэсэн хэрэг биш болохоор мэдэгдэл ирээгүй байлаа ч итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхийнхээ үүднээс шалгалтанд байлцаж, санал бодлоо илэрхийлэхэд буруудах зүйлгүй юм.

Хорин есдүгээр зүйл

Татвараас зайлсхийх талаар зөвлөгөө өгөх зэргийг хориглох

Тайлбар

ТМНБ нь Монгол улсын татварын мэргэжсэн нягтлан бодогчийн хуулийн 1 дүгээрт заасны дагуу "татварын мэргэжилтнийхээ хувьд бие даасан, шударга голч байр суурин дээр байж, татвараа өөрөө тодорхойлох системийн хүрээнд татвар төлөгчийн итгэлийг хүлээн, татварын хууль тогтоомжид заасан татвар төлүүлэх үүргийн зохих биелэлтийг хангах" явдлыг эрхэм зорилго болгоно. Ийм эрхэм зорилго тавьсан татварын мэргэжсэн нягтлан бодогч өөрөө болон түүний харилцагч татвар төлөгч нь улс болон орон нутгийн татвар ногдуулалт, татвар хураалтаас зайлсхийх, улс, орон нутгийн татварын буцаан олголтыг хууль бусаар авах талаар заавар зөвлөгөө өгөх болон үүнтэй адилтгах аливаа үйлдэл хийж болохгүй бөгөөд ийм

буруутай үйлдэл хийсэн татварын мэргэжсэн нягтлан бодогчийг татварын мэргэжсэн нягтлан бодогчид тэнцэхгүй гэж үзнэ. Иймээс тус зүйлд ТМНБ-ийг дээр дурдсан үйлдэл хийхийг хориглосон болно. Мөн ТМНБ-ийн хууль нь дээр дурдсан үйлдэл хийсэн татварын мэргэжсэн нягтлан бодогчийг нэг жил хүртэлх хугацаагаар татварын мэргэжсэн нягтлан бодогчийн ажил эрхлэхийг нь зогсоох, эсвэл хориглох сахилгын арга хэмжээ авахаас гадна (тус хуулийн 39 дүгээр зүйл) эрүүгийн хариуцлагад татаж, 3 хүртэлх жилийн хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх хорих ял шийтгэх, эсвэл 1 сая хүртэлх төгрөгийн торгох ял шийтгэнэ (тус хуулийн 72 дүгээр зүйл).

Энэхүү үйлдлийг татварын мэргэжсэн нягтлан бодогч өөрөө үйлдэж, мөн ийм үйлдэл хийх талаар татвар төлөгчид заавар зөвлөгөө өгөх тохиолдолд уг хуулийн заалт үйлчилнэ.

Тус зүйлд заасан *"татвар"* гэдэгт тухайн ТМНБ-ийн үйл ажиллагаанд хамаарах татвар төдийгүй бүх татвар хамаарна. Тиймээс ТМНБ-ийн үйл ажиллагаанд үл хамаарах гаалийн татвараас зайлсхийх талаар заавар зөвлөгөө өгсөн тохиолдолд ч бас тус хуулийн заалт нэгэн адил үйлчилнэ.

"Заавар өгөх" гэдэг нь татвар төлөгчид татвараас зайлсхийх талаар тодорхой арга зам зааж өгөхийг хэлэх ба *"зөвлөгөө өгөх"* гэдэг нь татвараас зайлсхийх арга замын талаар татвар төлөгчтэй зөвлөлдөж, татвараас зайлсхийх талаар нааштай хариу өгөхийг хэлнэ. Татвараас зайлсхийх талаар заавар зөвлөгөө өгөхтэй *"адилтгах үйлдэл"* гэдэг нь жишээлбэл, тодорхой нэг этгээдэд татвараас зайлсхийх санаа төрүүлэх зорилгоор тодорхой санал бодол илэрхийлэхийг хэлэх бөгөөд уг тохиолдолд тус зүйлийн заалт үйлчилнэ.

Татварын мэргэжсэн нягтлан бодогчийн өгсөн татвараас зайлсхийх талаарх заавар зөвлөгөөг тухайн татвар төлөгч хэрэгжүүлсэн эсэхээс үл хамааран тус зүйлд заасны дагуу ТМНБ-д хариуцлага хүлээлгэнэ. Бодит байдал дээр татвараас зайлсхийх үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд ч гэсэн татварын мэргэжсэн нягтлан бодогчид арга хэмжээ авна.

ТМНБ-оос бусад этгээд татвараас зайлсхийх талаар заавар зөвлөгөө өгөхдөө татварын мэргэжсэн нягтлан бодогчийн нэрийг ашигласан тохиолдолд ТМНБ-ийн нэрийг ашиглахыг хориглох буюу ТМНБ-ийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох хуулийг давхар зөрчсөнд тооцож, ТМНБ-ийн нэрийг ашигласан буюу ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулсан, мөн татвараас зайлсхийхийг уриалсан хэргээр хариуцлагад татна. Тухайн этгээд нь ТМНБ-ийн нэрийг ашиглаагүй тохиолдолд ТМНБ-ийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу татвараас

зайлсхийхийг татвар төлөгчид уриалсан хэрэгт татагдана.

Гучдугаар зүйл

ТМНБ-ийн итгэл найдварыг хөсөрдүүлэх үйлдэл хийхийг хориглох тухай

Тайлбар

ТМНБ-д өмнөө тавьсан эрхэм зорилгынхоо дагуу итгэл найдвар даах, нэр хүндээ авч явах шаардлага зүй ёсоор тавигддаг тул тус зүйлд ТМНБ-ийн итгэл найдвар даах чадвар болон нэр хүндээ өндөрт өргөж явах талаар заасан болно. Өөрөөр хэлбэл, ТМНБ нь ТМНБ-ийн хүлээсэн итгэл найдварыг даалгүй ТМНБ-ийн нэр хүндийг хугалах аливаа үйлдэл хийж болохгүй. Энд өгүүлэх ТМНБ-ийн нэр хүнд, итгэл найдвар гэдэг нь бүх ТМНБ-ийг хамарсан ойлголт болохоос бус хувь хүнийх нь талаас авч үзээгүй болно. Гэхдээ ТМНБ-ийн итгэл найдвар, нэр хүндийг авч явахын тулд ТМНБ бүрт хүчин чармайлт гаргах шаардлага зайлшгүй тавигдана. ТМНБ-ийн нэр хүнд, итгэл найдварыг өндөрт өргөж явахад ТМНБ нарын хамтын хичээл зүтгэл хэрэгтэй гэдгээс үзвэл энэ нь зүй ёсны хэрэг юм.

Гучин нэгдүгээр зүйл

Нууцыг хадгалах үүрэг

Тайлбар

ТМНБ-д үүрэгт ажлаа эрлэх явцад харилцагч татвар төлөгчийн орлого, эд хөрөнгө, өр зээл болон бусад хөрөнгө, аж ахуйн үйл ажиллагаатай нь хамааралтай нууцыг мэдэх боломж их тохиолддог. Татвар төлөгч нь өөрийн үйл ажиллагаатай холбогдох нууцыг ТМНБ-д мэдээлснээр татвар төлөх үүргийн биелэлт сая зохих ёсоор хангагдах боломжтой болох тул ТМНБ болон татвар төлөгчийн хоорондын харилцаа нь харилцан бие биедээ итгэлцэх итгэл дээр тулгуурлан цааш үргэлжлэх ёстой билээ.

Иймд уг зүйл нь ТМНБ-д харилцагч татвар төлөгчийнхөө нууцыг хадгалах үүрэг хүлээлгэх ба ТМНБ нь зохих шалтгаангүйгээр үйл ажиллагааныхаа явцад олж авсан мэдээллийг бусдад задруулах буюу өөр зорилгоор ашиглахыг хориглосон билээ. ТМНБ нь татварын мэргэжсэн нягтлан бодогчийн ажил эрхлэхээ больсон тохиолдолд ч гэсэн уг үүргийг биелүүлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл ТМНБ нь тухайн үүрэгт ажлаа гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг холбогдох татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулах, шүүхэд гэрчээр дуудагдан татвар төлөгчид хамаарах нууцыг мэдээлэх шаардлагатай тохиолдол болон бусад хууль тогтоомжинд заасны дагуу татвар төлөгчид хамаарах нууцыг мэдээлэх үүрэг

хүлээснээс бусад тохиолдолд зохих шалтгаангүйгээр татвар төлөгчийн нууцыг бусдад дамжуулах, эсвэл тухайн татвар төлөгчөөс холбогдох зөвшөөрөл авалгүйгээр түүнд хамаарах нууц мэдээллийг хувьдаа ашиглах эрхгүй. Тухайн этгээд нь ТМНБ-ийн ажил эрхлэхээ больсон тохиолдолд ч дээр дурдсан үүргийг биелүүлэх ёстой.

Уг зүйлийг зөрчсөн этгээдэд сахилгын ердийн хариуцлага (Тус хуулийн 40 дүгээр зүйл) хүлээлгэхээс гадна эрүүгийн хариуцлагад татна. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчөөс зарга үүсгэсэн тохиолдолд тухайн ТМНБ-ийг 2 жил хүртэлх хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх хорих ял, эсвэл 200 мянга хүртэлх төгрөгийн торгох ялаар (Тус хуулийн 74 дүгээр зүйл) шийтгэнэ.

Гучин хоёрдугаар зүйл
Зөвлөлийн дүрмийг сахих үүрэг

Тайлбар

ТМНБ нь харьяалагдах ТМНБ-дын зөвлөл төдийгүй ТМНБ-дын холбооны дүрмийг сахин биелүүлэх үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл, ТМНБ-дын зөвлөл болон Монголын ТМНБ-дын холбоо нь ТМНБ ба ТМНБ-дын зөвлөлийг өөрийн гишүүнээ болгох бөгөөд ТМНБ-ийн хуулинд тулгуурлан зохион байгуулагдсан хуулийн этгээд тул аль аль нь тухайн гишүүдтэйгээ холбоотой байж тэднийг удирдан чиглүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүрэг бүхий бие даасан байгууллага юм. Тус байгууллагын шууд буюу дам гишүүн болох ТМНБ нь өөрийн удирдах байгууллагын дүрмийг сахин биелүүлэх үүрэг зүй ёсоор хүлээнэ.

Гэхдээ ТМНБ-дын зөвлөл болон Монголын ТМНБ-дын холбоо нь татварын мэргэжсэн нягтлан харьяалагдах байгууллагынхаа дүрмийг зөрчсөн тохиолдолд уг этгээдийг ТМНБ-ийн ажил хийхэд тэнцэхгүй гэж үзлээ ч өөрийн гишүүнээс хасах эрхгүй байдаг. Иймээс ТМНБ-дын холбоо болон зөвлөлийн дүрмийг зөрчсөн этгээдэд холбогдох дүрмийг сахих биелүүлэх үүргийн тухай заалт оруулж ирсэн бөгөөд уг үүргийг биелүүлээгүй тохиолдолд тус хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу сахилгын ердийн хариуцлага хүлээлгэх тухайгаа ҮТЕГ-ын даргад уламжлан холбогдох арга хэмжээ авна.

Гучин гуравдугаар зүйл
Албан контор нээж ажиллуулах үүрэг

Тайлбар

ТМНБ нь татварын мэргэжсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулах албан контортой байна. ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулах албан контор нь "ТМНБ-ийн албан контор" гэсэн нэгдмэл нэртэй

байна. ТМНБ нь татварын мэргэжсэн нягтлан бодогчийн албан контор хоёроос дээш байгуулж болохгүй.

Ийнхүү татварын мэргэжсэн нягтлан бодогчийн албан конторт тоон хязгаарлалт тавьж буй нь дараах учир шалтгаантай. Үүнд:

1. ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулах ажлын байрыг нэгээр хязгаарлаж тогтоох нь хууль зүйн харилцааг оновчтой болгоход тохиромжтой гэж үзсэнээс юм.

2. ТМНБ-ийн ажлын цар хүрээ өргөсөн нэг хүний хүчээр хяналт тавьж хүчрэхгүй болсон тохиолдолд албан конторын зүгээс хяналт тавих замаар зохицуулалт хийснээр ТМНБ бус этгээд гарч ирэхээс сэргийлэх боломжтой болох юм. Энэ хоёр шалтгааны улмаас ТМНБ-ийн албан конторт тоон хязгаарлалт тогтоосон болно.

Энд өгүүлэх ТМНБ-ийн албан контор гэдэг нь татварын мэргэжсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа байнга явуулах газрыг хэлэх бөгөөд байнга татварын мэргэжсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулж буй эсэхийг гаднах хаяг, техник, тоног төхөөрөмжийн байдал болон ажилтан буй эсэх зэрэг бодит хүчин зүйлсийг харгалзан үзсэний үндсэн дээр тогтооно.

ТМНБ-ийн албан конторыг хуулийн этгээд гэж хүлээн зөвшөөрч болохгүй. Учир нь ТМНБ-ийн эрх нь зөвхөн тухайн татварын мэргэжсэн татварын нягтлан бодогч болох хувь хүнд олгосон зүйл тул байнга үйл ажиллагаа явуулах зорилгоор байгуулагддаг хуулийн этгээд гэж үзэх нь тохиромжгүй юм.

Бусад ТМНБ-ийн байгуулсан ТМНБ-ийн албан конторт хөлслөгдөн ажиллах ТМНБ нь өөрийн хувийн үйлчлүүлэгчтэй байж, татварын мэргэжсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулахгүй тохиолдолд ТМНБ-ийн албан контор байгуулах шаардлагагүй.

*Гучин дөрөвдүгээр зүйл
Албан дэвтэр хөтлөх үүрэг*

Тайлбар

ТМНБ-ийн эрхлэх үүрэгт ажил нь маш нарийн бөгөөд хожим нь хүндрэлтэй асуудал гарах тохиолдол байдаг тул явуулсан ажил хэргээ тодорхой болгох шаардлагатай байдаг. Иймд тодорхой албан дэвтэр хөтлөн, шаардлагатай зүйлсийг тэмдэглэнэ.

Татвар төлөгчийг төлөөлөн татварын үйл ажиллагаа явуулах, татварын холбогдолтой бичиг баримт боловсруулах болон татварын холбогдолтой зөвлөгөө өгсөн тохиолдолд тухайн зөвлөгөө авсан татвар төлөгчийг тус тусад нь бүртгэх бөгөөд ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулах бүрдээ тухайн үйл ажиллагааны агуулга болон явцын талаар тэмдэглэл хөтөлсөн байх шаардлагатай. Тухайн ажлын

агуулга болон явцын талаар тэмдэглэл хөтлөхдөө итгэмжлэн явуулж буй татварын үйл ажиллагаа болон боловсруулсан татварын холбогдолтой баримт бичиг, татварын холбогдолтой өгсөн зөвлөгөөний талаар түүний агуулга, явцыг ойлгогдох хэнмжээнд тэмдэглэсэн байхад хангалттай. Уг бүртгэлийг 5 жил хадгална.

Гучин тавдугаар зүйл
Хөлслөгдөн ажиллаж буй этгээдэд тавих хяналт

Тайлбар

Аливаа этгээдийг хөлсөлж ажиллуулах этгээд нь тухайн хөлслөгдөн ажиллах этгээдэд хяналт тавих үүрэг хүлээдэг. Ялангуяа ТМНБ-ийн хувьд авч үзвэл ТМНБ-ийн эрх нь тухайн татварын мэргэжсэн нягтлан бодогчид өөрт нь олгогдсон буюу ТМНБ-ийн үйл ажиллагаа нь дагнасан үйл ажиллагаа тул тухайн хөлсөлж ажиллуулах этгээдийн аливаа үйлдлээс болж татвар төлөгчийн итгэлийг хөсөрдүүлэх явдал гаргаж болохгүй тухай тус зүйлд заасан. Иймээс ТМНБ нь татвар төлөгчийн итгэлийг хүлээн ТМНБ-ийн эрүүл саруул тогтолцоог авч явахын тулд ТМНБ-ийн дэргэд хөлслөгдөн ажиллах этгээдэд хяналт тавьж байх үүргийн талаар ТМНБ-ийн хуулинд тодорхой заан өгснөөр ТМНБ-ийн ажилдаа хандах ухамсрын төвшинг дээшлүүлэх зорилгоор ТМНБ-ийн дэргэд хөлслөгдөн ажиллах этгээдэд хяналт тавих тухай заалтыг оруулж ирсэн болно.

ТМНБ-ийн ажилд хөлслөгдөн ажиллах этгээд болон бусад туслах ажилтанд хяналт тавих заалтыг ТМНБ-ийн хуулийн 53 дугаар зүйлийн 2 дугаар хэсгийн 6 дугаарт болон ТМНБ-ийн зөвлөлийн дүрэмд тусгах бөгөөд ТМНБ-ийн дэргэд хөлслөгдөн ажиллах этгээдэд ямар аргаар хэрхэн хяналт тавих тухай асуудал нь ТМНБ-ийн зөвлөлийн дотоодод шийдэх асуудал юм.

ТМНБ-ийн хуулийн төсөлд заасан "ТМНБ-ийн дэргэд хөлслөгдөн ажиллах этгээд болон бусад туслах ажилтан" гэдэгт ТМНБ-ийн хөлсөлж авсан этгээдээс гадна хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй хэдий ч ТМНБ-ийн үйл ажиллагааны хүрээнд ТМНБ-ийн удирдлага болон хяналтан дор ажиллах бусад бүх этгээд хамаарна. Түүнчлэн ТМНБ-ийн ажилд оролцох гэр бүлийн ажилтан ч хамрагдана.

Гучин зургадугаар зүйл
Зөвлөгөө өгөх үүрэг

Тайлбар

Тус зүйлд ТМНБ нь харилцагч татвар төлөгчийнхөө татвараас зайлсхийсэн буруутай үйлдлийн талаар мэдсэн тохиолдолд тухайн

буруутай үйлдлээ засч залруулахыг татвар төлөгчид зөвлөхийн зэрэгцээ ҮТЕГ–т тэр тухай мэдэгдэх үүрэг хүлээнэ гэж заасан. ТМНБ нь үүрэгт ажлаа гүйцэтгэх үедээ харилцагч татвар төлөгч нь татвараас зайлсхийж буй талаар болон татвараас зайлсхийх санаа өвөрлөн данс бүртгэл давхар хөтөлсөн, мөн өөр нэрийн дор үйл ажиллагаа явуулж буй талаар мэдсэн бол зүгээр хараад өнгөрүүлж болохгүй. Энэ нь татвар төлөх үүргийн зохих биелэлтийг хангах явдлыг эрхэм зорилго болгосон ТМНБ–ийн хувьд огт байж болшгүй зүйл бөгөөд харин ч энэхүү алдааг засч залруулах талаар шаардах нь ТМНБ–ийн үүрэг билээ.

ТМНБ нь үйл ажиллагаа гүйцэтгэх явцдаа харилцагч татвар төлөгч нь дор дурдсан буруутай үйлдэл явуулж буй талаар мэдсэн тохиолдолд тухайн татвар төлөгчид хандан буруутай үйлдлээ засч залруулах талаар зөвлөгөө өгөхийн зэрэгцээ энэ тухай ҮТЕГ болон бусад шатны татварын байгууллагад мэдэгдэх ёстой.

1. Хууль бусаар татвар ногдуулалт болон татвар хураалтаас зайлсхийх
2. Хууль бусаар татварын буцаан олголт эдлэх
3. Татварын жишиг тооцоход хэрэг болохуйц баримт материалыг бүхэлд нь буюу нэг хэсгийг нь нуун дарагдуулах

Тус зүйлийн заалтыг зөрчсөн этгээдэд татвараас зайлсхийх талаар татвар төлөгчид зөвлөгөө өгсөн хэмээн (39 дүгээр зүйл) сахилгын арга хэмжээ авахаас гадна эрүүгийн хариуцлагад татах бөгөөд энэ тохиолдолд 1 жил хүртэлх хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх хорих ял, эсвэл 200 мянга хүртэлх төгрөгийн торгох ял (75 дүгээр зүйл) шийтгэнэ.

Гучин долдугаар зүйл
ТМНБ–ийн үйл ажиллагааг зогсоох тухай

Тайлбар

Тус зүйлд мэргэжсэн нягтлан бодогч болон өмгөөлөгч нь мэргэжсэн нягтлан бодогчийн хууль, өмгөөлөгчийн хуулинд заасны дагуу тухайн ажил үүрэг эрхлэхийг зогсоох болон хориглох сахилгын арга хэмжээ шийтгэгдээд, уг шийтгэлийн хугацаа дуусаагүй үед ТМНБ–ийн үйл ажиллагаа эрхэлж болохгүй тухай заасан. Түүнчлэн ТМНБ нь хөлс урамшуулал бүхий төр, олон нийтийн байгууллагын ажил эрхэлж буй үедээ нэгэн адил ТМНБ–ийн ажил эрхэлж үл болох тухай заасан.

(1) Сахилгын арга хэмжээгээр үйл ажиллагааг нь зогсоох

ТМНБ нь мэргэжсэн нягтлан бодогч болон өмгөөлөгч нь үйл

ажиллагааг нь зогсоох болон хориглох сахилгын арга хэмжээ шийтгэгдэж буй үедээ ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулж болохгүй.

ТМНБ болох эрхтэй байлаа ч дээр дурдсан үйл ажиллагаа зогсоох болон хориглох сахилгын арга хэмжээ шийтгэгдэж буй тохиолдолд тухайн этгээдийг ТМНБ-оор бүртгэхээс татгалзана (тус хуулийн 18 дугаар зүйл). Түүнчлэн ТМНБ-ийн эрх авсны дараа мэргэжсэн нягтлан бодогч болон өмгөөлөгчийн ажил эрлэхийг зогсоох буюу хориглох арга хэмжээ шийтгэгдсэн тохиолдолд уг шийтгэлийн хугацаа дуусах хүртэл хугацаанд ТМНБ-ийн ажил эрхэлж болохгүй. Мөн өөр ажил давхар эрхлэх ТМНБ нь тухайн ажил эрхлэх бүртгэлээс хасагдах сахилгын арга хэмжээ шийтгүүлж буй тохиолдолд ТМНБ болох эрхгүй этгээд (тус хуулийн 18 дугаар зүйл) гэдэгт хамааран, ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулах эрхээ алдана.

(2) Хөлс урамшуулал бүхий төр олон нийтийн ажил эрхлэх тохиолдолд ТМНБ-ийн үйл ажиллагаа эрхлэхийг зогсоох тухай

ТМНБ нь хөлс урамшуулал бүхий төр, олон нийтийн ажилд орсон тохиолдолд тухайн алба гүйцэтгэх хугацаанд ТМНБ-ийн ажил эрхлэхийг хориглоно.

Хөлс урамшуулал бүхий төр, олон нийтийн ажил гэдэг нь УИХ-ын гишүүн болон орон нутгийн олон нийтийн байгууллагын гишүүний үүрэгт ажил болон орон тооны бус ажлаас бусад хөлс урамшуулал бүхий ажлыг хэлэх бөгөөд УИХ, шүүх, төрийн засаг захиргааны байгууллага, хот, аймаг, сумын төр олон нийтийн байгууллагын ажил хамаарна.

Дээр дурдсан ажил эрхлэх этгээд нь ТМНБ-оор бүртгүүлэхээс өмнө хөлс урамшуулал бүхий ажил эрхэлж байсан тохиолдолд ТМНБ-ийн эрх эзэмшиж байсан ч гэсэн тухайн хөлс урамшуулал бүхий ажлыг эрхэлж буй хугацаанд ТМНБ-оор бүртгэхээс татгалзана (тус хуулийн 18 дугаар зүйл). ТМНБ-оор бүртгүүлсний дараа дээр дурдсан хөлс урамшуулал бүхий төр, олон нийтийн байгууллагын ажил эрхлэх болсон тохиолдолд тус хугацаанд ТМНБ-ийн ажил эрхлэхийг нь зогсооно.

(3) ТМНБ-ийн үнэмлэхийг буцаах тухай

ТМНБ-ийн үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд тухайн этгээд болон түүний хууль ёсны төлөөний этгээд нь ТМНБ-ийн үнэмлэхийг мэргэжлийн зөвлөлд нэн даруй буцаан олгоно. (тус хуулийн 22 дугаар зүйл)

Зургадугаар бүлэг

ТМНБ-ийн хүлээх хариуцлага

Гучин наймдугаар зүйл Сахилгын хариуцлагын төрөл

Тайлбар

ТМНБ-д дараах 3 төрлийн сахилгын арга хэмжээ авна. Үүнд:

1. Дохио сануулга
2. Нэг жил хүртэлх хугацаагаар ТМНБ-ийн ажил эрхлэхийг зогсоох
3. ТМНБ-ийн ажил эрхлэхийг хориглох

"Дохио сануулга" гэдэг нь сахилгын хариуцлага авагдахаар буруутай үйлдэл хийсэн ТМНБ-д хандан зөвхөн дохио сануулга өгөхийг хэлэх бөгөөд ТМНБ-ийн ажил үүрэг болон ТМНБ-ийн эрхэнд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй. ТМНБ-д харилцагч үйлчлүүлэгчийнх нь итгэл найдвар туйлийн чухал байдаг. Иймд ТМНБ-ийн цаашид ажил төрөлдөө анхаарах зүйлийн талаар "дохио сануулга" өгөх арга хэмжээ авсан ч гэсэн тухайн ТМНБ нь харилцагч үйлчлүүлэгчдийнхээ дунд нэр хүндээ алддаг. Чухам энэхүү талыг нь ашиглан тухайн ТМНБ-д захиргааны арга хэмжээ болох сахилгын хариуцлага хүлээлгэх нь үр дүнтэй арга бөгөөд үүний үр дүнд нийт ТМНБ-ийн нэр хүнд болон тэдэнд татвар төлөгчдийн хүлээлгэх итгэл найдварыг хэвээр хадгалахад уг сахилгын арга хэмжээний зорилго агуулагдана.

"ТМНБ-ийн ажил эрхлэхийг зогсоох" гэдэг нь ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах гэсэн үг бөгөөд уг төрлийн сахилгын арга хэмжээ авагдсан ТМНБ нь татвар төлөгчтэй байгуулсан гэрээгээ цуцлах шаардлагатай. Энэ тохиолдолд тухайн ТМНБ-ийн бүртгэлд аливаа нөлөө үзүүлэхгүй бөгөөд ТМНБ-дын зөвлөлийн гишүүний эрхийн асуудлыг тухайн ТМНБ-ийн харъяалагдах ТМНБ-дын зөвлөлийн дүрэмд заасны дагуу тухайн эрхийг нь зогсоох буюу өөр төрлийн дотоод ажил үүргийн шинжтэй хариуцлагын арга хэмжээ авч болно.

ТМНБ-д хүлээлгэх хариуцлагын дундаас хамгийн хүнд хариуцлага нь "ТМНБ-ийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох" сахилгын арга хэмжээ юм. Уг сахилгын арга хэмжээ хүлээсэн этгээд нь ТМНБ-ийн эрхээ алдах ба ТМНБ-ийн бүртгэлээс хасагдан ТМНБ-дын зөвлөлөөс гарна. Уг сахилгын хариуцлага хүлээсэн этгээд нь ТМНБ-ийн 4 дүгээр зүйлийн 7 дугаарт заасны дагуу шийтгэл хүлээсэн өдрөөс хойш 3 хүртэлх жилийн хугацаа өнгөрөөгүй тохиолдолд ТМНБ-оор дахин бүртгүүлэх эрхгүй.

Гучин есдүгээр зүйл

Татвараас зайлсхийх талаар зөвлөгөө өгөх зэрэг үйлдэлд сахилгын арга хэмжээ авах

Тайлбар

Тус зүйл болон 40 дүгээр зүйлд ТМНБ–д сахилгын арга хэмжээ хүлээлгэхтэй холбогдох ҮТЕГ–ын даргын эрх мэдэл болон сахилгын арга хэмжээний бүтэц, түүнд тавигдах шаардлагын талаар заасан болно. 39 дүгээр зүйл болон 40 дүгээр зүйлд заасан сахилгын хариуцлагыг ТМНБ–ийн хууль бус үйл ажиллагааны шинж чанараас шалтгаалан хүлээлгэнэ.

ТМНБ–ийн аливаа хууль зөрчсөн үйлдэл дотроос хамгийн ноцтой хэрэг нь ТМНБ санаатайгаар үнэнд харшилсан татварын үйл ажиллагаа явуулан татвараас зайлсхийх этгээдтэй үгсэн нийлэх явдал юм. Түүнчлэн ТМНБ нь дээр дурдсан буруутай үйлдэл хийсэн тохиолдолд тухайн этгээдэд ТМНБ–ийн үйл ажиллагаа эрхлэхийг зогсоох, эсвэл, ТМНБ–ийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох сахилгын арга хэмжээ авах талаар заасан болно. Өөрөөр хэлбэл ТМНБ нь өөрт олгогдсон татвар төлөгчийн баримт материал дээр тулгуурлан татварын мэргэжсэн ажилтны хувьд тухайн мэдлэг болон туршлагандаа үндэслэн татвар төлөгчийн хууль бус үйл ажиллагааг мэдсэн хэрнээ татвар төлөгчийн талд орж хууль бус татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулах буюу санаатайгаар татварын бичиг баримт хуурамчаар үйлдэж, татвараас зайлсхийх талаар татвар төлөгчид заавар зөвлөгөө өгөх болон үүнтэй адил төрлийн үйл ажиллагаа эрхлэн явуулсан тохиолдолд тухайн этгээдийг 1 жил хүртэлх хугацаагаар ТМНБ–ийн үйл ажиллагаа явуулахыг хориглох сахилгын арга хэмжээгээр шийтгэх тухай уг зүйлд заасан болно.

ТМНБ нь ямагт анхаарал болгоомжтой ажиллаж хууль ёсны хэм хэмжээнд тулгуурлан татварын нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай атал санаатайгаар үнэнд харшилсан татварын үйл ажиллагаа явуулах нь туйлийн байж болшгүй гэмт үйлдэл юм. Тус зүйлийн 1 дүгээр хэсэгт дээр дурдсан гэм буруутай үйл ажиллагаа явуулсан ТМНБ–д хүлээлгэх сахилгын арга хэмжээний тухай заасан болно.

ТМНБ нь санаатайгаар бус буюу анхаарал болгоомжгүйн улмаас дээр дурдсан буруутай үйл ажиллагаа явуулж, сахилгын арга хэмжээгээр шийтгэгдэх болсон тохиолдолд, өөрөөр хэлбэл анхаарал болгоомжгүйн улмаас хууль бус татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулж, алдаатай баримт материал боловсруулж, татвараас зайлсхийх талаар заавар зөвлөгөө өгөх буюу дээр дурдсантай адил

төрлийн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд, тухайн үйл ажиллагааг санаатайгаар явуулсан нь тогтоогдоогүй буюу анхаарал болгоомжгүйн улмаас үйлдсэн нь нотлогдсон тохиолдолд тухайн этгээдийг 1 жил хүртэлх хугацаагаар ТМНБ-ийн ажил явуулах эрхийг нь хасах сахилгын арга хэмжээгээр шийтгэнэ. Өөрөөр хэлбэл, ТМНБ-ийн ажилдаа цалгар назгай хандсаны улмаас ноцтой хор уршигт хүрэх үйл ажиллагаа явуулсаны нь төлөө уг сахилгын хариуцлага хүлээлгэж байгаа юм.

Тус зүйлд заасан сахилгын арга хэмжээ болон 19 дүгээр зүйлийн 2 дугаарт заасан ТМНБ-ийн бүртгэлийг хүчингүй болгох тухай заалт нь хоорондоо хэрхэн холбогдож байгаа талаар анхаарал хандуулах хэрэгтэй. Уг зүйлд (ТМНБ-ийн хуулийн 39, 40 дүгээр зүйл) заасан сахилгын арга хэмжээг ҮТЕГ-ын даргын шийдвэрээр тухайн ТМНБ-д хүлээлгэдэг бол ТМНБ-ийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дугаарт заасан арга хэмжээг ТМНБ-ийн мэргэжлийн зөвлөлөөс авч хэрэгжүүлдэг бөгөөд уг арга хэмжээ нь тухайн ТМНБ-ийн үйлдсэн гэм буруутай үйлдэл нь туйлийн хүнд хэлбэртэй гэж үзсэн тохиолдолд ТМНБ-ийн зөвлөлөөс авах эцсийн арга хэмжээ болно.

Мөн ТМНБ нь далдуур хууль бус үйл ажиллагаа явуулан өөрөө татвараас зайлсхийсэн нь тогтоогдвол ТМНБ-ийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дугаар хэсэгт заасны дагуу тухайн этгээдийг ТМНБ-ийн бүртгэлээс хасах арга хэмжээг ТМНБ-ийн зөвлөлөөс авч хэрэгжүүлэх болно. ТМНБ нь харилцагч татвар төлөгчийнхөө төлөө дээр дурдсан үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол татвараас зайлсхийсэн мөнгөн хөрөнгөний нийт үнийн дүн, нийгэмд үзүүлэх хор нөлөө, татвараас зайлсхийх болсон үндэслэл, татвараас зайлсхийх үйл ажиллагаанд оролцсон байдал зэргийг харгалзан ҮТЕГ-ын дарга холбогдох хуулийн зүйл ангид тохирсон сахилгын арга хэмжээ авна. ТМНБ-д сахилгын хариуцлага хүлээлгэх тухай ТМНБ-ийн хуулинд заасан ҮТЕГ-ын даргын эрх мэдлийн хүрээнд шийдэхэд хүндрэлтэй асуудал гарсан тохиолдолд ТМНБ-ийн мэргэжлийн зөвлөлд хандах ба мэргэжлийн зөвлөл тухайн гэм буруутай этгээдийг ТМНБ-ийн бүртгэлээс хасах арга хэмжээ авна.

Дөчдүгээр зүйл
Сахилгын ердийн хариуцлага

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-д хамаарах ноцтой гэж тооцогдох гэм буруутай үйлдэл бус ТМНБ-ийн ердийн хууль бус үйл ажиллагаанд хүлээлгэх сахилгын хариуцлага

болон хариуцлага хүлээлгэх арга ба түүнд тавигдах шаардлагын тухай заасан болно.

ТМНБ нь харилцагч татвар төлөгчийнхөө татварын тайлан болон бусад холбогдох бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн тохиолдолд, эсвэл, уг хууль болон татварын бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд тухайн ТМНБ-д хүлээлгэх хариуцлагын талаар уг зүйлд заасан болно.

ТМНБ-д тухайн гэм буруутай үйлдлийнх нь шинж чанараас хамааран дохио сануулга өгөх, нэг жил хүртэлх хугацаагаар ТМНБ-ийн ажил эрхлэхийг зогсоох, ТМНБ-ийн ажил эрхлэхийг хориглох болон ТМНБ-ийн бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ авна. ТМНБ нь хууль бус үйл ажиллагаа явуулсан тохиолдолд (санаатайгаар үнэнд харшилсан татварын үйл ажиллагаа) нэг жил хүртэх хугацаагаар ТМНБ-ийн ажил эрхлэхийг зогсоох, ТМНБ-ийн ажил эрхлэхийг хориглох болон ТМНБ-ийн бүртгэлээс хасах сахилгын арга хэмжээний аль нэгээр шийтгэнэ. Энэ тохиолдолд ТМНБ нь анхаарал болгоомжгүйн улмаас тухайн гэм буруутай үйлдэл хийсэн нь тогтоогдвол дохио сануулга өгөх, эсвэл, нэг жил хүртэлх хугацаагаар ТМНБ-ийн ажил эрхлэхийг зогсоох сахилгын арга хэмжээ авна. Бусад сахилгын ердийн хариуцлага хүлээлгэх тохиолдолд ч гэсэн эдгээр сахилгын хариуцлагыг шалгуур болгон сахилгын хариуцлагын төрөл болон хүнд, хөнгөнийг тогтооно.

Дөчин нэгдүгээр зүйл
Сахилгын хариуцлагын процедур

Тайлбар

Тус зүйлд сахилгын арга хэмжээ авагдах буруутай үйл ажиллагаа явуулсан ТМНБ-ийг олж илрүүлсэн этгээд сахилгын арга хэмжээ авах эсэх асуудлыг шийдвэрлэх эрх мэдэл бүхий ҮТЕГ-ын даргад тухайн ТМНБ-ийн талаар мэдээлж, зохих арга хэмжээ авахыг шаардаж болох тухай заасан бөгөөд ҮТЕГ-ын дарга гэм буруутай ТМНБ-д сахилгын хариуцлага хүлээлгэх тохиолдолд баримтлах сахилгын арга хэмжээ авах процедурын талаар заасан болно. Үүнд:

- (1) ТМНБ нь ямагт бие даасан, шударга голч байр суурин дээр байж, өмнөө хүлээсэн эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд татвар төлөгч төдийгүй энгийн олон түмэнд ТМНБ-ийн хийх ажлын талаар өчүүхэн ч эргэлзээ төрүүлж болохгүй билээ. Иймд ТМНБ-ийн үйлдсэн сахилгын арга хэмжээ авагдахуйц аливаа буруутай үйл ажиллагааны талаар аливаа этгээд мэдэж буй тохиолдолд

ҮТЕГ–ын даргад мэдэгдэж зохих арга хэмжээ авахыг шаардаж болно. Өөрөөр хэлбэл ТМНБ–ийн талаар тухайн ТМНБ нь санаатайгаар хууль бус татварын үйл ажиллагаа төлөөлөн явуулж, хуурамч бичиг баримт боловсруулан, татвараас зайлсхийх талаар заавар зөвлөгөө өгөх болон дээр дурдсантай адил төрлийн үйл ажиллагаа явуулсан буюу татварын хууль тогтоомж зөрчсөн гэдгийг нь мэдэж буй хичнээн ч этгээд байсан ҮТЕГ–ын даргад мэдээлж, зохих хариуцлага хүлээлгэхийг шаардаж болно.

- (2) Сахилгын арга хэмжээ нь ТМНБ–ийн үүрэгт ажлыг журамлах чухал арга хэмжээ бөгөөд өөрөөр хэлбэл эрүүгийн хэргийг шүүн таслах шүүх хурлын шийдвэртэй дүйцэхүйц хэмжээний шийтгэл гэж үзэж болно. Иймд сахилгын арга хэмжээ хүлээлгэхдээ тухайн асуудалд маш ул суурьтай, нарийн нягт хандах хэрэгтэй. ҮТЕГ–ын дарга тухайн ТМНБ сахилгын арга хэмжээ авагдахуйц гэм буруутай үйлдэл хийсэн талаар мэдээлэл авсан тохиолдолд уг мэдээлэлийн ул мөрөөр шалгалт хийж тухайн ТМНБ–ийн хууль бус үйл ажиллагаа явуулсныг нь тогтоон сахилгын арга хэмжээ авахаар шийдвэр гаргасан тохиолдолд уг ТМНБ–д урьдчилан мэдэгдэж цаг товлон тогтоож, тухайн ТМНБ–д өөрөө болон төлөөний этгээдээрээ дамжуулан уг үйлдлээ тайлбарлах боломж олгох хэрэгтэй.

Тухайн ТМНБ–д өөрийн үйлдлээ тайлбарлах боломж олгосон хэдий ч тухайн этгээд өөрөө биечлэн болон төлөөний этгээдээрээ дамжуулан тайлбар хийгээгүй буюу тайлбар хийсэн ч гэсэн хангалттай бус тохиолдолд ҮТЕГ–ын дарга холбогдох сахилгын арга хэмжээ авна.

- (3) ҮТЕГ–ын дарга ТМНБ–д сахилгын арга хэмжээ авахдаа холбогдох үндэслэлийг бичсэн баримт бичиг үйлдэн тухайн ТМНБ болон ТМНБ–дын зөвлөлд мэдэгдэх хэрэгтэй. ТМНБ–д сахилгын арга хэмжээ авах болсон талаар мэдэгдэхдээ мэдэгдэх хуудсыг ТМНБ–ийн нэрсийн жагсаалтан дахь тухайн ТМНБ–ийн хаягаар илгээнэ.

Сахилгын арга хэмжээгээр тухайн этгээдийн ТМНБ–ийн ажил эрхлэхийг зогсоосон тохиолдолд уг шийтгэл хүлээсэн өдрөөс шийтгэлийн хугацааг хүчин төгөлдөр гэж үзэх бөгөөд тухайн этгээдийг ТМНБ–ийн эрхээ алдаж, ТМНБ–ийн бүртгэлээс хасагдсанд тооцно.

Дор дурдсан шалтгааны улмаас сахилгын хариуцлагын арга хэмжээ үйлчилж эхлэх хугацааг тус арга хэмжээ шийтгэгдсэн өдрөөс эхлэн тооцно.

ТМНБ нь татвар төлөгчийн татвар төлөх үүргийн биелэлтийг хангахын тулд ТМНБ–ийн бие даасан үйл ажиллагаа явуулна гэж

хуулинд заасан байдаг. Өөрөөр хэлбэл уг үйл ажиллагаа явуулах эрх нь хуулиар хамгаалагдсан байдаг төдийгүй тухайн үйл ажиллагааг дурэм журмын дагуу явуулах үүрэг хүлээсэн байдаг. Иймд сахилгын арга хэмжээ авах эсэх асуудлыг шүүхээр хэлэлцэх болсон тохиолдолд шүүхийн шийдвэр гарах хүртэл сахилгын арга хэмжээ үл үйлчлэх тул уг хугацаанд ТМНБ-ийн ажилд үл тэнцэх этгээд ТМНБ-ийн үйл ажиллагаа чөлөөтэй явуулах боломжтой байдаг. Энэ нь сахилгын арга хэмжээний үр дүнд муугаар нөлөөлнө. Ийм учраас сахилгын арга хэмжээ авах шийдвэр гаргасан өдрөөс эхлэн тухайн шийтгэл хүчин төгөлдөр гэж үзэх зайлшгүй шаардлагатай. Ийнхүү сахилгын арга хэмжээ авагдсан этгээд захиргааны хариуцлагын хуулийн дагуу эрхээ сэргээх талаар гомдол мэдүүлж болох бөгөөд шаардлагатай үед сахилгын арга хэмжээ авах хугацааг зогсоох боломжтой тул тус хуулийн зүйл нь ТМНБ-ийн эрхийг хөндөхгүй гэж үзэж болно.

Дөчин хоёрдугаар зүйл

Сахилгын арга хэмжээ шийтгэх тухай олон нийтэд мэдэгдэх

Тайлбар

ҮТЕГ-ын дарга дохио сануулга өгөх, ТМНБ-ийн ажил эрхлэхийг зогсоох буюу хориглосон сахилгын арга хэмжээ авсан тохиолдолд уг арга хэмжээний тухай нэн даруй сонин хэвлэлээр олон нийтэд мэдээлэх ёстой. Ийнхүү тухайн ТМНБ-д сахилгын арга хэмжээ авагдсан тухай мэдээлснээр холбогдох татвар төлөгч хууль бус үйл ажиллагааны улмаас хохирол амсахаас урьдчилан сэргийлж болно.

Түүнчлэн ТМНБ-ийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон сахилгын арга хэмжээ авсан тохиолдолд ТМНБ-ийн зөвлөлд нэн даруй мэдэгдэн, тухайн этгээдийг ТМНБ-ийн бүртгэлээс хасуулах хэрэгтэй бөгөөд бүртгэлээс хасагдсан этгээдийн талаар олон нийтэд сонин хэвлэлээр мэдээлэх хэрэгтэй. (Тус хуулийн 21 дүгээр зүйл)

Долдугаар бүлэг

Мэргэжлийн зөвлөл

Дөчин гуравдугаар зүйл

Мэргэжлийн зөвлөл байгуулах тухай

Тайлбар

Мэргэжлийн зөвлөл нь ТМНБ-ийн шалгалт явуулж, тэнцсэн этгээдэд ТМНБ-ийн эрх олгож, ТМНБ-оор бүртгэх, ТМНБ-дыг удирдлагаар

хангаж, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих (ТМНБ-ийн хуулийн 19 дүгээр зүйлд заасан бүртгэл хүчингүй болгох үйл ажиллагаа үүнд хамаарна.) зорилго агуулна.

Мэргэжлийн зөвлөл нь дараах үүрэгт ажил эрхэлнэ. Үүнд:

1. ТМНБ-ийн шалгалт зохион байгуулах
2. ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн этгээдэд ТМНБ-ийн эрх олгох
3. ТМНБ-ийн шалгалтанд оролцох эрх авах этгээдийн зайлшгүй эзэмшсэн байх ёстой мэргэжлийн түвшинг тогтоох, шалгалтанд оролцох эрх олгох
4. ТМНБ-ийн шалгалтаас чөлөөлөгдөх этгээдийг тогтоох
5. ТМНБ-ийн шалгалтанд тэнцсэн этгээд болон ТМНБ-оор бүртгүүлэх этгээдийг тогтоох
6. ТМНБ-оор бүртгүүлэх болон бүртгэлээс хасагдах этгээдийг тогтоох (ТМНБ-ийн бүртгэл баталгаажуулах болон дахин бүртгэх үйл ажиллагаа хамаарна.)
7. ТМНБ-дын үйл ажиллагааг удирдах
8. ТМНБ-дын үйл ажиллагаанд хяналт тавих

Дөчин дөрөвдүгээр зүйл
Мэргэжлийн зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

Тайлбар

Тус зүйл нь мэргэжлийн зөвлөлийн зохион байгуулалт, бүтцийн тухай заасан болно.

Мэргэжлийн зөвлөл нь төрийн ба төрийн бус байгууллагын төлөөлөлтэйгээр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулагдана. ҮТЕГ-ын дэд дарга нь мэргэжлийн зөвлөлийн даргаар байнга ажиллах бөгөөд мэргэжлийн зөвлөлийг төлөөлөх, удирдах үүрэг хүлээхийн зэрэгцээ зөвлөлийн бусад 4 гишүүнийг нэр цохон томилно.

Мэргэжлийн зөвлөлийн гишүүд нь 2 жилийн хугацаагаар томилогдох бөгөөд сул орон тоо гарч хүн авч ажиллуулах тохиолдолд тухайн этгээдийн ажиллах хугацааг өмнөх этгээдийн бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар тогтооно. Мэргэжлийн зөвлөлийн гишүүд нь орон тооны бус байна. Мэргэжлийн зөвлөлийн гишүүд нь дахин сонгогдох боломжтой.

Мэргэжлийн зөвлөлд орон тооны нарийн бичгийн дарга ажиллах ба мэргэжлийн зөвлөлийн дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зөвлөх ажиллуулж болно. Нарийн бичгийн дарга болон зөвлөхийг мэргэжлийн зөвлөлийн дарга сонгоно.

Дөчин тавдугаар зүйл

Зөвлөлөөс шийдвэр гаргах арга хэлбэр

Тайлбар

Тус зүйл нь мэргэжлийн зөвлөлийн шийдвэр гаргах арга хэлбэрийн талаар заасан болно. Мэргэжлийн зөвлөлөөс гаргах аливаа шийдвэрийг олонхийн саналын дагуу шийдвэрлэнэ.

*Дөчин зургадугаар зүйл
ТМНБ-ийн шалгалтын комисс*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-ийн шалгалтын комиссын гишүүд болон ТМНБ-ийн шалгалтын комиссын тухай заасан болно. ТМНБ-ийн шалгалтын асуудал боловсруулах, шалгалт зохион байгуулах, шалгалт дүгнэх, шалгалтанд тэнцсэн этгээдийг тогтоох зорилгоор мэргэжлийн зөвлөлд ТМНБ-ийн шалгалтын комисс ажиллуулна.

ТМНБ-ийн шалгалтын комиссын гишүүнийг мэргэжлийн зөвлөлийн гишүүн болон ҮТЕГ-ын ажилтнуудын дундаас мэргэжлийн зөвлөлийн санал болгож дэвшүүлсэнээр ҮТЕГ-ын дарга сонгох бөгөөд ТМНБ-ийн шалгалтын комиссын гишүүд нь орон тооны бус байх болно. ТМНБ-дын зөвлөлийн гишүүд нь дахин сонгогдох боломжтой хэдийч шалгалтын комиссын гишүүд нь ТМНБ-ийн шалгалт эхлэхэд томилогдож, шалгалт дуусахад тухайн үүрэгт ажил нь дууссанд тооцогдоно.

*Дөчин долдугаар зүйл
Зөвлөлийн дарга болон гишүүдэд тавигдах шаардлага*

Тайлбар

Тус зүйлд мэргэжлийн зөвлөлийн дарга болон гишүүдэд тавих шаардлагын тухай заасан болно. Үүнд:

1. Мэргэжлийн зөвлөлийн дарга болон гишүүн нь Монгол улсын иргэн байх
2. Мэргэжлийн зөвлөлийн гишүүд нь ҮТЕГ-ын 3 ажилтан болон татвар, нягтлан бодох бүртгэлийн талаар мэдлэг туршлагатай, 3-аас доошгүй жил төрийн захиргааны байгууллагад ажилласан болон их дээд сургуульд багшилсан 2 хүн байхаар хуулинд заасан болно.

ТМНБ нь татварын өндөр мэргэжилтэй байх зайлшгүй шаардлагатай байдаг. Иймд ТМНБ-ийг бүртгэх, удирдах, хяналт тавих үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн гишүүн нь илүү өндөр мэдлэг боловсролтой байх шаардлагатай. ҮТЕГ-ын ажилтан нь татвар буюу татварын

бодлогын талаар мэдлэг боловсрол зайлшгүй эзэмшсэн байдаг тул эдгээр ажилтаны дотроос мэргэжлийн зөвлөлийн гурван гишүүнийг сонгох хэрэгтэй. Мөн бусад хоёр гишүүнээр татвар болон нягтлан бодох бүртгэлийн талаар зохих мэдлэг болон боловсрол эзэмшсэн бөгөөд төрийн захиргааны байгууллага болон их дээд сургуульд 3-аас доошгүй жил ажилласан хүнийг сонгож ажиллуулбал мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ. Иймд ТМНБ-ийн хуулинд мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр дээр дурдсан шаардлагыг хангах хүнийг сонгох тухай заасан болно.

3. Хуулинд заасан үүргийг биелүүлэх чадавх эзэмшсэн буюу мэргэжлийн болон ёс суртахууны шаардлага хангах хүнийг мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр сонгоно.

Мэргэжлийн зөвлөл нь шударга голч байр сууринаас ТМНБ-ийг бүртгэх, удирдах, хяналт тавих үйл ажиллагаа явуулах байгууллага тул уг зөвлөлийн гишүүд нь татвар болон татварын бодлогын талаар мэргэжлийн зохих мэдлэг чадвахи эзэмшсэн буюу тухайн үүрэгт ажлаа хууль журмын дагуу шударгаар хэрэгжүүлж чаддаг байх ёстой. Түүнчлэн уг хуулинд заасан гишүүний үүргээ биелүүлэх өндөр чадавхи эзэмшсэн байх хэрэгтэй.

Дөчин наймдугаар зүйл
Зөвлөлийн дарга болон гишүүдийг чөлөөлөх

Тайлбар

Тус зүйлд мэргэжлийн зөвлөлийн дарга болон гишүүнийг тухайн үүрэгт ажлаас нь хэрхэн чөлөөлөх талаар тодорхой заасан болно. Мэргэжлийн зөвлөлийн дарга болон гишүүнийг дараах тохиолдолд тухайн үүрэгт ажлаас нь чөлөөлнө. Үүнд:

1. Эрүүл мэндийн байдлаас болж ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд
 2. Тухайн этгээд зөвлөлөөс гарах хүсэлт тавьсан тохиолдолд
 3. Хууль тогтоомж болон мэргэжлийн ёс зүйг зөрчсөн тохиолдолд
 4. Эрүүгийн ял шийтгэх тухай шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон тохиолдолд
- Бусад төрлийн аливаа хууль тогтоомжинд тулгуурлан тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болсон тохиолдолд мэргэжлийн зөвлөлөөс тухайн этгээдийг хасагдсанд тооцно.
5. Өөр ажилд шилжсэний улмаас мэргэжлийн зөвлөлийн гишүүний үүргийг давхар гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд

ҮТЕГ–ын ажилтан болохынхоо хувьд мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр сонгогдсон этгээд нь өөр ажилд шилжсэн буюу ҮТЕГ–ын ажилтан байхаа больсон тохиолдолд мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр ажиллах боломжгүй болно. Иймд тухайн этгээдийг ҮТЕГ–аас гарсан өдрөөр мэргэжлийн зөвлөлийн гишүүнээс гарсанд шууд тооцно. Гэхдээ, тухайлбал их дээд сургуульд багшийн ажил эрхэлж байсан мэргэжлийн зөвлөлийн гишүүн тухайн ажлаа өөрчлөн аж ахуйн нэгж байгууллага удирдах болсон тохиолдолд тухайн этгээдийг мэргэжлийн зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх зайлшгүй шаардлаггүй. Гэхдээ уг этгээд нь шинээр эрхлэх ажил болон мэргэжлийн зөвлөлийн ажлыг хавсран гүйцэтгэх боломжгүй болсоны улмаас мэргэжлийн зөвлөлөөс гарах хүсэлт өөрөө гаргасан тохиолдолд тухайн үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.

Дөчин есдүгээр зүйл
Мэргэжлийн зөвлөлийн бүрэн эрх

Тайлбар

Тус зүйлд мэргэжлийн зөвлөлийн бүрэн эрхийн талаар заасан болно.

Мэргэжлийн зөвлөл нь уг хуульд заасан эрхээс гадна дараах эрхийг хэрэгжүүлэх болно. Үүнд:

① ТМНБ–ийн үйл ажиллагаатай холбоотой дэлгэрэнгүй заалт болон ёс зүйн хэм хэмжээний заалт боловсруулах, боловсронгуй болгох, мөрдүүлэх, хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа явуулах

② ТМНБ–ийн шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг тодорхойлох

③ ТМНБ–ийн шалгалтын комиссоос эрхлэн явуулах шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж, тэнцсэн этгээдэд ТМНБ–ийн эрх олгох

④ ТМНБ–ийн гэрчилгээ болон ТМНБ–ийн эрхийн үнэмлэх олгож ТМНБ–ийг бүртгэх үйл ажиллагаа явуулах

ТМНБ–ийн шалгалтанд тэнцсэн этгээд (шалгалтаас чөлөөлөгдсөн этгээд үүнд хамаарна.) нь ТМНБ–оор бүртгүүлсний дараа ТМНБ–ийн гэрчилгээ болон эрхийн үнэмлэх авна. ТМНБ–ийн гэрчилгээг харилцагч татвар төлөгчийн нүдэнд тусахуйц газар ТМНБ–ийн албан конторт байрлуулах ёстой бөгөөд ТМНБ–ийн эрхийн үнэмлэх нь тухайн этгээдийг ТМНБ болохыг баталсан биеийн байцаалт болох тул байнга биедээ авч явах хэрэгтэй.

⑤ Гадаад улс оронд ТМНБ-ийн шалгалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх болон шалгалтанд тэнцсэн бөгөөд ТМНБ-оор бүртгүүлсэн этгээдэд Монгол улсын ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, ТМНБ-ийн гэрчилгээ буюу эрхийн үнэмлэх олгох ажлыг хариуцана.

Гадаад улс оронд ТМНБ-ийн шалгалт явуулахдаа зөвхөн шалгалт өгөх эрх авсан этгээдээс шалгалт авах бөгөөд гадаад улсын иргэн шалгалтанд тэнцсэн тохиолдолд (Шалгалтаас чөлөөлөгдсөн этгээд хамаарна.) мэргэжлийн зөвлөл тухайн этгээдийг ТМНБ-оор бүртгүүлсний дараа Монгол улсын ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, ТМНБ-ийн эрхийн үнэмлэх, гэрчилгээ олгоно.

⑥ ТМНБ ёс суртахууны хэм хэмжээг сахиж буй эсэх талаар мэргэжлийн зөвлөл биечлэн болон татварын байгууллага, холбогдох харилцагч буюу үйлчлүүлэгчийн мэдэгдлийн дагуу тухайн ТМНБ-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг нь ҮТЕГ-ын даргад мэдээлнэ.

Тус зүйлд мэргэжлийн зөвлөл ТМНБ-ийн үйл ажиллагаанд хяналт тавих бүрэн эрхтэй тухай заасан бөгөөд мэргэжлийн зөвлөл нь өөрийн сайн дураар болон татварын алба, харилцагч татвар төлөгчийн хүсэлтээр хяналтын үйл ажиллагаа явуулж, хяналт явуулсан талаар ҮТЕГ-ын даргад мэдээлнэ.

⑦ Хууль тогтоомж болон мэргэжлийн зөвлөлийн тогтоосон ёс суртахууны хэм хэмжээг зөрчсөн этгээдийг ТМНБ-ийн бүртгэлээс хасах болон ТМНБ-ийн үйл ажиллагаа эрхлэхийг нь зогсоохтой холбогдсон хяналтын үйл ажиллагаа явуулах

Тус зүйлд 19 дүгээр зүйлд заасны дагуу мэргэжлийн зөвлөл нь ТМНБ-ийн бүртгэлийг хүчингүй болгох арга хэмжээ аваад зогсохгүй ҮТЕГ-аас ирүүлсэн тухайн ТМНБ-ийн үйл ажиллагааг зогсоох талаарх мэдэгдэл дээр үндэслэн тухайн этгээдийг ТМНБ-ийн бүртгэлээс хасах болон ТМНБ-ийн үйл ажиллагааг зогсоохтой холбогдсон хяналтын үйл ажиллагааг явуулах эрхтэй тухай заасан.

⑧ ТМНБ-дод явуулах төрөл бүрийн сургалт, давтан сургалтыг ҮТЕГ-ын сургалтын албанд хариуцуулан явуулах

ТМНБ-дод зориулж явуулах сургалт семинар болон ТМНБ-ийн бүртгэлээ баталгаажуулах этгээдэд зориулсан сургалт нь тухайн ТМНБ татварын мэргэжилтнийхээ хувьд зайлшгүй мэдвэл зохих шинэ татварын систем болон татварын бодлогын хэрэгжилттэй холбоотой асуудлуудын талаар ТМНБ-д тодорхой ойлголт өгч тэдэнд ТМНБ-ийн

үйл ажиллагааг хэрхэн зүй зохистойгоор хэрэгжүүлэх талаар дадлага туршлага эзэмшүүлэх тул ихээхэн ач холбогдолтой байдаг. Энэ чухал ажлыг ҮТЕГ–ын сургалтын албанд хариуцуулан явуулснаар зохих хэмжээнд боловсрогдсон сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан сургалтын үйл ажиллагаа явуулах боломж бүрдэх бөгөөд тухайн хууль зүйн үндсийг нь уг зүйлд заасан болно.

⑨ Татварын хуулийн хэрэгжилтийг сайжруулах болон хяналт тавих бодлогыг боловсронгуй болгох талаар ҮТЕГ–т хандаж тавих санал болон зөвлөмж

Татварын хуулийн хэрэгжүүлэх бодлого болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлогыг боловсронгуй болгох ажил нь ҮТЕГ–ын үүрэгт ажил хэдий ч мэргэжлийн зөвлөл ТМНБ–ийн үйл ажиллагааг удирдаж, төлөвшүүлэхийн тулд ҮТЕГ–ын үйл ажиллагааг боловсронгуй болгох бодлого боловсруулж, ҮТЕГ–т санал болгон дэвшүүлж болох бөгөөд ҮТЕГ нь тухайн саналыг хүлээн авч хэрэгжүүлэх замаар мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд дам дэмжлэг үзүүлж болох тухай уг зүйлд заасан болно. Мөн тухайн нөхцөл байдлаас шалтгаалан ҮТЕГ биечлэн уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ шууд мөнгөн тусламж үзүүлэх боломжтой.

⑩ Татварын сурталчилгаа таниулга болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах ажил эрхлэх

Уг зүйлд ТМНБ нь татварын мэргэжилтэн болон ТМНБ–ийн байр сууринаас татвар төлөгчид хандан татварын талаар төрөл бүрийн мэдээлэл өгөх хэрэгтэй буюу мэргэжлийн зөвлөл нь ҮТЕГ–аас тусдаа татвар төлөгчид зориулж татварын сурталчилгаа таниулга явуулж өөрөө татвараа тодорхойлох системийг боловсронгуй болгоход хувь нэмэр оруулах шаардлагатай талаар заасан болно.

⑪ Татварын холбогдолтой сургалт явуулж буй их дээд сургууль, байгууллага (Захиргааны байгууллага үүнд хамаарна.) –уудад тал бүрээр туслалцаа үзүүлэх

Тус зүйлд мэргэжлийн зөвлөл нь ТМНБ–ийг удирдаж, тэдний үйл ажиллагааг төлөвшүүлэхийн тулд ирээдүйд ТМНБ болох боловсон хүчнийг бэлтгэн сургаж буй их дээд сургууль болон татварын холбогдолтой сургалт семинар зохион байгуулах байгууллага (Захиргааны байгууллага хамаарна.)–уудад хандан тэдний үйл ажиллагааг дэмжих талаар заасан болно.

⑫ Тус зүйлд ТМНБ–ийн шалгалт авч явуулах, ТМНБ–ийн ажил

эрхлэх эрхийн бичиг хэвлэн гаргах, бүртгэх, дахин бүртгэл явуулах болон төрөл бүрийн сургалтын ажлыг зохион байгуулахдаа мэргэжлийн зөвлөл нь зохих хэмжээний ажлын хөлс шаардах эрхтэй болох талаар заасан болно.

Тавьдугаар зүйл
Мэргэжлийн зөвлөлийн санхүүжилт

Тайлбар

Тус зүйлд мэргэжлийн зөвлөлийн санхүүжилтийн талаар заасан болно.

1. Мэргэжлийн зөвлөл нь үйл ажиллагаагаа уг хуулийн 49 дүгээр зүйлд заасан үйлчилгээний хөлсөөр санхүүжүүлж явуулна.

Мэргэжлийн зөвлөл нь ТМНБ-дын үйл ажиллагаан дээр тулгуурласан байгууллага бөгөөд мэргэжлийн зөвлөлөөс гарах бүх зардлыг уг хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу үйлчилгээний хөлсөөр нөхнө.

2. Мэргэжлийн зөвлөл нь санхүүгийн эх үүсвэрийг зөвхөн үндсэн эрхээ хэрэгжүүлэхэд зарцуулна.

Мэргэжлийн зөвлөл нь санхүүгийн эх үүсвэрээ уг хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу үйлчилгээний хөлсөөр бүрдүүлдэг тул тухайн хөрөнгө мөнгийг зүй бусаар зарцуулах ёсгүй. Тухайн санхүүгийн эх үүсвэрийг зөвхөн үүрэгт ажлаа хэрэгжүүлэхэд захиран зарцуулах хэрэгтэй тухай уг зүйлд заасан болно.

3. Мэргэжлийн зөвлөл нь тогтоосон хугацаанд жилийнхээ орлого буюу зарлагыг тодорхойлсон санхүүгийн тайланг ҮТЕГ-ын даргад тавина.

Мэргэжлийн зөвлөл тухайн санхүүгийн тайлангаа хяналт шалгалтын эрх бүхий ҮТЕГ-ын даргад өгөх үүрэг хүлээнэ.

Тавин нэгдүгээр зүйл
Мэргэжлийн зөвлөлд тавих хяналт

(Тайлбар)

Тус зүйлд ҮТЕГ-ын дарга мэргэжлийн зөвлөлийн үүрэгт ажил болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих талаар заасан болно.

Наймдугаар бүлэг
Монголын ТМНБ-дын зөвлөл

Тавин хоёрдугаар зүйл
ТМНБ-дын зөвлөл

Тайлбар

ТМНБ нь тухайн эрхэм зорилгодоо тулгуурлан харилцагч татвар төлөгчийн итгэлийн хүлээн, татвар төлүүлэх үүргийн зохих биелэлтийг хангах мэдлэг боловсролтой байж татварын холбогдолтой хууль тогтоомжийн талаар мэргэжлийн зохих мэдлэг эзэмшсэн байх хэрэгтэй. Иймд холбогдох хяналт шалгалтын байгууллагын зүгээс ТМНБ–д сахилгын хариуцлага хүлээлгэж шийтгэх нь гол бус юм. ТМНБ бие даан татварын хууль тогтоомж судлан, мэргэжлийн зэргээ дээшлүүлэхэд анхаарал тавьж ТМНБ–ийн үйл ажиллагааны чанар чансааг дээшлүүлэх талаар идэвхтэй ажиллах шаардлагатай нь зүй ёсны хэрэг юм. Түүнчлэн ТМНБ–ийн бие даасан байгууллагын гишүүд нь харилцан бие биеэ урамшуулж, ТМНБ–дын үүрэг зорилгыг биелүүлэхэд анхаарал тавьж, аливаа хууль зөрчсөн үйл ажиллагаа гарахаас урьдчилан сэргийлэх талаар идэвх зүтгэл гарган, хамтран ажиллах шаардлагатай. Иймд ТМНБ–дын зөвлөл нь гишүүдээ удирдлагаар ханган байнгийн холбоотой байж, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих зорилго агуулна.

ТМНБ нь тухайн эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд бие даасан үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд болох ТМНБ–дын зөвлөлийг байгуулна. ТМНБ–оор бүртгэхийн тулд зайлшгүй ТМНБ–дын зөвлөлд гишүүнээр элссэн байх хэрэгтэй бөгөөд тухайн этгээд ТМНБ–оор бүртгүүлмэгц ТМНБ–дын зөвлөлд бүртгүүлэн гишүүнээр элсэх замаар ТМНБ–ийн үйл ажиллагаа явуулна.

(1) ТМНБ–дын зөвлөлийг байгуулах тухай

Тус зүйлд ТМНБ–дын зөвлөлийг хэрхэн байгуулах талаар заасан болно.

Татварын албадын хариуцсан газар бүрт ТМНБ–дын зөвлөл байгуулах боломжтой. Зарчмын хувьд татварын албадын хариуцсан газрыг нэг дүүрэг гэж тооцон, тухайн дүүрэг тутамд ТМНБ–дын зөвлөл байгуулах хэрэгтэй. Гэхдээ Монгол улсад үл оршин суух ТМНБ–ийг гишүүнээр элсүүлсэн ТМНБ–дын зөвлөл нь нийслэлийн татварын газарт харъяалагдах ТМНБ–дын зөвлөлд харъяалагдана.

(2) ТМНБ–дын зөвлөлийн зорилго

ТМНБ–дын зөвлөл нь ТМНБ–ийг гишүүнээр элсүүлсэн бөгөөд бие даасан үйл ажиллагаа явуулах байгууллага юм. ТМНБ нь татварын мэрэгжилтнийхээ хувьд бие даасан шударга байр сууринаас тухайн харилцагч этгээдийн татвар төлөх үүргийг зүй зохистойгоор хэрэгжүүлэх ажил эрхэлдэг тул их итгэл найдвар хүлээсэн байдаг. Ийм эрхэм зорилго болон үүрэг хариуцлага хүлээсэн ТМНБ нь удирдан зохицуулах байгууллага болох ҮТЕГ–т харъяалагдах төдийгүй тухайн

үйл ажиллагаагаа сайжруулж, чанарын түвшинг нь дээшлүүлэхийн тулд идэвх санаачлагатай ажиллаж, татварын эрүүл саруул үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

ТМНБ-дын зөвлөл нь ТМНБ тухайн үүрэгт ажил буюу зорилгоо биелүүлэхэд болон ТМНБ-ийн үүргийг сахин биелүүлж, ТМНБ-ийн үйл ажиллагааг боловсронгуй болгоход хувь нэмэр оруулах, салбар зөвлөл болон гишүүдийнхээ үйл ажиллагааг удирдах, хяналт тавих зорилгоор байгуулагдана.

(3) ТМНБ-ийн онцлог шинж болон нэр

ТМНБ нь ТМНБ-ийн хуулинд заасны дагуу байгуулагдах хуулийн этгээд юм. ТМНБ-ийн зөвлөл нь өндөр зорилго өмнөө тавих бөгөөд чухал үүрэгт ажил эрхэлдэг тул уг зөвлөлийг ТМНБ-дын зөвлөл гэж нэрлэнэ. ТМНБ-дын зөвлөлөөс бусад этгээд бусад хууль тогтоомжинд өөрөөр заагаагүй бол ТМНБ-дын зөвлөл гэсэн нэрийг хэрэглэж үл болно. (Тус хуулийн 68 дугаар зүйл)

*Тавин гуравдугаар зүйл
ТМНБ-дын зөвлөлийн дүрэм*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-дын зөвлөлийг байгуулах талаар заасан болно.

ТМНБ нь ТМНБ-дын зөвлөл байгуулахдаа тухайн зөвлөлийн дүрмийг боловсруулж, ҮТЕГ-ын даргаар батлуулна.

ТМНБ-дын зөвлөлийн үйл ажиллагаа нь ТМНБ болон татварын албанаас ихээхэн хамаардаг тул ТМНБ-дын зөвлөлийн дүрмийг ҮТЕГ-ын даргаар батлуулах хэрэгтэй.

(1) Зөвлөлийн дүрэмд тусгах зүйл болон өргөдөл

ТМНБ-дын зөвлөлийн дүрэмд

- 1) ТМНБ-дын зөвлөлийн нэр болон албан конторын байршил
- 2) Зөвлөлд гишүүнээр элсэх болон зөвлөлөөс гарах тухай заалт
- 3) Эрх мэдэл бүхий гүйцэтгэх албан тушаалтантай холбогдсон заалт
- 4) Зөвлөлийн хурлын тухай заалт
- 5) ТМНБ-ийн нэр хүндийг авч явахтай холбогдсон заалт
- 6) ТМНБ-ийн ажилд хөлслөгдөн ажиллаж буй этгээд болон бусад ажилтанд хяналт тавих тухай заалт
- 7) Зөвлөлийн хураамжийн талаарх заалт
- 8) Ерөнхий ажил болон санхүүгийн талаарх заалт оруулж, эдгээр зүйлсийг тэмдэглэх хэрэгтэй.

- 1) ТМНБ-дын зөвлөлийн нэр, албан конторын байршлын тухай тогтоохдоо гол ажил хэргийг эрхлэх албан контороос гадна дахин

албан контор байгуулсан тохиолдолд тухайн албан конторынхоо байршлыг мөн адил тэмдэглэх талаар заах хэрэгтэй. (ТМНБ–дын зөвлөлийн салбар болон харилцагч татвар төлөгчтэй холбоо барих ажил эрхлэх албан конторыг дээр дурдсан шинээр байгуулагдах албан контор гэж тооцохгүй.)

- 2) Зөвлөлд гишүүнээр элсэх болон зөвлөлөөс гарах тухай заалтад тухайн этгээд ТМНБ–оор бүртгүүлсэн өдрөөс эхлэн зөвлөлд гишүүнээр элссэнд тооцох тухай болон ТМНБ–дын зөвлөлийн хооронд гишүүнчлэлийн шилжилт хийх, гишүүн болох эрх, холбоонд элсэх, зөвлөлөөс гарах шалтгаан, тэдгээртэй холбогдох бичиг баримтыг хэрхэн бүрдүүлэх талаар тусгана.
- 3) Гүйцэтгэх эрх мэдэл бүхий тушаалын тухай заалтандаа энэхүү албан тушаалын төрөл, тоо, уг албан тушаалд тохоон томилох арга хэлбэр, уг албан үүргийн хугацааг заана. Зөвлөлийн дарга, дэд дарга заавал байх ёстой бөгөөд үүнээс бусад албан тушаал болон тэдгээрийн тоог зөвлөлийн дүрмээр батална.

Монголын ТМНБ–дын зөвлөл нь зохих нэр бүхий ажлыг бий болгох буюу тухайн албан тушаал нь удирдах албан тушаал байх тохиолдолд уг албан тушаалын талаар холбооны дүрэмд тусгах ёстой бөгөөд харин удирдах албан тушаал бус тохиолдолд дүрэмд заавал тусгах шаардлаггүй.

- 4) Хуралдааны тухай заалтдаа хуралдааны төрөл, хурлын гишүүд, хурал нээх тухай болон хуралдаанаас шийдвэр гаргах арга хэлбэр, хуралдаанаар авч хэлэлцэх асуудлын тухай тусгана. Монголын ТМНБ–дын зөвлөл нь гишүүдийнхээ хэргийг өөрөө удирдаж зохицуулдаг бие даасан байгууллага тул Монголын ТМНБ–дын зөвлөлийн бүхий л гол ажил хэргийг хурлаар авч хэлэлцэх нь зүйтэй бөгөөд ТМНБ–дын хуулинд зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай болон зардал төсөв, тайлан тооцоог заавал нэгдсэн хуралдаанаар авч хэлэлцэх шаардлагатай тухай заасан болно.
- 5) ТМНБ–ийн өмнөө тавигдсан эрхэм зорилго, хүлээсэн хариуцлага нь тэднээс нэр хүндээ өндөрт авч явахыг болон өргөн мэдлэгтэй байхыг шаарддаг. Монголын ТМНБ–дын зөвлөл нь энэхүү зорилгыг хэрэгжүүлэх байгууллага тул тухайн гишүүдийнх нь нэр хүндээ өндөрт өргөж явах тухай заалт их чухал юм. Монголын ТМНБ–дын зөвлөлийн гишүүд нь гишүүнийхээ нэр хүндийг өндөрт өргөж явах, ТМНБ–ийн чадвараа дээшлүүлэхийн төлөө харилцан хичээн ажиллах ёстой бөгөөд гишүүдийн сахилгын үндсэн журам болон сахилгын хариуцлагын тухай заах хэрэгтэй.
- 6) Аливаа этгээд хүн хөлслөн авч ажиллуулах тохиолдолд хөлсөлж

буй этгээд нь хөлслөгдөгч этгээддээ хяналт тавих нь мэдээжийн хэрэг бөгөөд ТМНБ-ийн эрх хувь хүнд оногддог болон ТМНБ-ийн ажил нь нийгэм, олон нийтийн шинж давамгайлсан, онцгой эрх бүхий ажил тул хөлслөгдөн ажиллаж буй этгээд нь татвар төлөгчийн итгэлийг хөсөрдүүлэх аливаа үйл ажиллагаа явуулж үл болох талаар холбооны дүрэмд тусгаж өгөх нь зүйтэй.

- 7) ТМНБ-дын зөвлөлд бие даасан үйл ажиллагаа явуулахад хөрөнгө мөнгө шаардлагатай тул тухайн гишүүдийн хураамжийн хэмжээг тогтоох, хураан авах, хураамжаа төлөөгүй этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх талаар зөвлөлийн дүрмэнд заах хэрэгтэй. Гишүүний хураамжийн хэмжээг тогтоохдоо зайлшгүй бүх гишүүдийн хураамжийн хэмжээг адил хэмжээнд тогтоох шаардлаггүй бөгөөд гишүүдийн хооронд зааг ялгаа тогтоох замаар хураамжийн хэмжээг тогтоож болно. Түүчлэн тодорхой хүндэтгэх шалтгаангүйгээр хураамжаа төлөөгүй тохиолдолд тухайн этгээдийг зөвлөлийн дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйд тооцож, сахилгын хариуцлага хүлээлгэж болно. Гэхдээ зөвхөн шийтгэл хүлээлгээд зогсохгүй тухайн этгээд нь ТМНБ-ийн байгууллагын ачаанаас үүрэлцэхгүй байна гэж үзэн, ТМНБ-ийн нэр хүнд, эрхийн чадвар бүрэн дүүрэн бус гэж үзэж болно.
- 8) Монголын ТМНБ-дын холбоо нь ТМНБ-дыг удирдан зохицуулах бие даасан байгууллага тул ТМНБ-дын холбооны баримтлах саналыг гаргах болон бусад ажил хэргийн талаар нэгдсэн хуралдаанаараа оруулан хэлэлцэж, нийт гишүүдийн саналын дагуу шийдвэрлэх нь мэдээжийн хэрэг билээ. Гэхдээ ТМНБ-дын холбооны гол ажил хэрэг болон нэгдсэн хуралдаанаар тогтоосон хураамж хураах, зардал төсөв хариуцсан хариуцлагатай ажилтан томилон ажиллуулах хэрэгтэй. Энэхүү гол ажил хэрэг, санхүүгийн ажлыг хэрхэн зохицуулах болон ямар ажилтанд хариуцуулахыг тогтоох хэрэгтэй.

(2) Зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Зөвлөлийн дүрэм нь ТМНБ-дын зөвлөлийн үйл ажиллагааны гол хууль зүйн баримт бичиг болох бөгөөд уг дүрэмд тулгуурлан ТМНБ-дын зөвлөл зохион байгуулагддаг тул зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулахаар болсон тохиолдолд ҮТЕГ-ын даргаас зохих зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах явдал нь тун чухал зүйл гэдгийг бодолцон үзэж, нэгдсэн хуралдаанаар энэ асуудлыг тусгайд нь авч үзэх хэрэгтэй бөгөөд гишүүдийн 2-ны 1-ээс дээш хувийн ирцтэйгээр, хуралдаанд оролцогчдын 3 -ны 2-оос дээш саналаар хуралдаанаас

шийдвэр гаргана. (Ердийн нэгдсэн хуралдаанаас гарах шийдвэр нь гишүүд 2–ны 1–ээс дээш хувийн ирцтэйгээр оролцож, дийлэнх нь тухайн шийдвэрийн талаар эерэг санал өгсөн тохиолдолд хүчинтэй).

*Тавин дөрөвдүгээр зүйл
ТМНБ–дын зөвлөл байгуулах үе*

Тайлбар

Тус зүйлд Монгол улсын ТМНБ–дын зөвлөл байгуулах үеийн тухай заасан болно.

Монголын ТМНБ–дын зөвлөлийг байгуулах явдал нь ТМНБ болон бусад холбогдох хүмүүсийн хувьд их ач холбогдолтой зүйл бөгөөд мөн энэ нь нийгэмтэй ч гүнзгий холбоотой байдаг тул холбоо байгуулахад зөвхөн ҮТЕГ–ын даргын зөвшөөрлийг авах төдийд хангалтгүй юм. Иймд ТМНБ–дын зөвлөл нь бүртгүүлснээр сая байгуулагдсанд тооцогдох болно.

*Тавин тавдугаар зүйл
Бүртгэл явуулах тухай*

Тайлбар

Тус зүйлд Монгол улсын ТМНБ–дын зөвлөлийг бүртгэхтэй холбогдсон заалт орсон болно. Монголын ТМНБ–дын зөвлөлийг бүртгэхдээ доорхи зүйлийн бүртгэлийг явуулна.

- 1) ТМНБ–дын зөвлөлийн зорилго, үйл ажиллагааны чиглэл
- 2) Зөвлөлийн нэр
- 3) Албан контор
- 4) Удирдан төлөөлөх этгээдийн овог нэр, хаяг, эрх мэдэл
- 5) Зөвлөлийн оршин тогтнох хугацаа, холбоо тарах тохиолдолд тэрхүү хугацаа болон тарах болсон шалтгаан зэрэг болно. Эдгээр бүртгэлд өөрчлөлт орсон тохиолдолд 2 долоо хоногийн дотор мэдэгдэн шинэчилсэн бүртгэл хийлгэх хэрэгтэй.

*Тавин зургадугаар зүйл
Холбоонд элсэх болон холбооноос гарах тухай*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ–дын холбоонд элсэх болон холбооноос гарах тухай заасан болно.

ТМНБ нь ТМНБ–оор бүртгүүлсэн тохиолдолд Монголын ТМНБ–дын зөвлөлийн гишүүн болно. Өөрөөр хэлбэл, бүртгүүлээд шууд

зөвлөлийн гишүүн болох систем үйлчилнэ. Энэхүү системийг бий болгосон зорилго нь Монголын ТМНБ-дын зөвлөл нь ТМНБ-ийн ажлыг үр бүтээлтэй явуулахад хувь нэмэр оруулдаг байгууллага тул ТМНБ-оор бүртгүүлэн ТМНБ-ийн эрх олж авсан аливаа этгээд ТМНБ-ийн ажил явуулахын тулд Монголын ТМНБ-дын зөвлөлд элсэх зайлшгүй шаардлагтай байдагт оршино.

ТМНБ нь ТМНБ-ийн ажлаа хийхээ больсон тохиолдолд, нас барсан тохиолдолд ТМНБ-ийн эрхийн чадваргүй тухай заалтад хамаарах болсон тохиолдолд, мөн ТМНБ-ийн бүртгэлийг хүчингүй болгох тухай заалтыг 1-д хамаарах болсон тохиолдолд Монголын ТМНБ-дын зөвлөлөөс гарна. Түүнчлэн ТМНБ-оор бүтгүүлсэн этгээдийг ТМНБ-ийн зөвлөлийн гишүүнд элссэнд тооцох систем үйлчлэх тул ТМНБ нь ТМНБ-ийн албан контороо харъяа ТМНБ-ийн зөвлөлөөс бусад ТМНБ-дын зөвлөл байгуулагдсан нутаг дэвсгэрт шилжүүлсэн тохиолдолд, эсвэл, тухайн харъяа ТМНБ-дын зөвлөлийн байгуулагдсан нутаг дэвсгэрт өөрчлөлт гарч, ТМНБ-ийн албан контор байрлах газар нь харъяа ТМНБ-ийн зөвлөлөөс бусад ТМНБ-дын зөвлөлийн харъяаны газарт хамаарах болсон тохиолдолд уг хаяг байршлын өөрчлөлт хөдөлгөөн хийгдсэн өдрөөр урьд харъяалагдаж байсан ТМНБ-дын зөвлөлийн гишүүнээс гарсан буюу тухайн шилжин очсон газрыг нь харъяалах ТМНБ-дын зөвлөлд гишүүнээр элссэнд тооцно.

*Тавин долдугаар зүйл
Гүйцэтгэх эрх мэдэл бүхий тушаал*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-дын зөвлөлийн гүйцэтгэх эрх мэдэл бүхий албан тушаалтны тухай заасан болно.

ТМНБ-дын зөвлөл нь зөвлөлийн дарга, орлогч дарга, зөвлөлийн дүрмээр баталсан бусад албан тушаалтантай байх бөгөөд удирдах албан тушаалын нэр, албан тушаалын тоо, ажиллах хугацааг зөвлөлийн дүрмээр батална.

Зөвлөлийн дарга нь ТМНБ-дын зөвлөлийг төлөөлөн удирдаж, бүх ажил хэргийг

ерөнхийд нь зохицуулан явуулах бөгөөд орлогч дарга нь зөвлөлийн даргын захирамжаар зөвлөлийн даргын ажил хэрэгт тусалж, зөвлөлийн дарга ямарваа нэгэн осол эндэгдэлд орсон тохиолдолд түүнийн ажлыг орлон гүйцэтгэх бөгөөд байхгүй үед нь ажил төрлийг нь зохицуулна.

Орлогч дарга хэд хэд буй тохиолдолд хэн нь ерөнхий даргын ажлыг

хэрхэн хийх вэ гэдгийг ерөнхий даргын тушаалаар шийднэ.

*Тавин наймдугаар зүйл
Нэгдсэн хуралдаан*

Тайлбар

Тус зүйлд Монголын ТМНБ–дын зөвлөлийн нэгдсэн хуралдааны тухай заасан болно.

Монголын ТМНБ–дын зөвлөлийн нэгдсэн хуралдаан нь ээлжит ба онцгой гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулагдана.

Ээлжит хуралдааныг Монголын ТМНБ–дын зөвлөлөөс жил бүр явуулна. Тайлан төсөв, ажлын тайлан гэх мэт тухайн оныхоо ажлыг тайлагнахын зэрэгцээ дараа жилийн ажлын төлөвлөгөө, хүлээгдэж буй төсөв зэргийн талаар авч хэлэлцэнэ.

Харин онц хуралдааныг шаардлагатай тохиолдолд зарлан хуралдуулж болох бөгөөд энэхүү хуралдаанаар гол төлөв яаралтай шийдвэрлүүлштэй асуудлыг авч хэлэлцэнэ. Ямар үед онц хуралдааныг зарлан хуралдуулах вэ гэдгийг зөвлөлийн дүрэмд заасны дагуу шийднэ.

Монголын ТМНБ–дын зөвлөл нь тухайн нэгдсэн хуралдаанаар ТМНБ–ийн хуулинд заасны дагуу зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудал болон тайлан төсвийн талаарх асуудлыг хэлэлцэх бөгөөд бусад зүйлийг зөвлөлийн дүрэмд заасны дагуу зохицуулна. Ийм ч учраас зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудал болон тайлан төсөв, зөвлөлийн дүрэмд заасан асуудлыг тухайн хуралдаанаар авч хэлэлцэх бөгөөд ТМНБ–дын зөвлөл нь үйл ажиллагаагаа явуулахдаа аль болохоор гишүүдийнхээ санал бодлыг сонсч байх хэрэгтэй бөгөөд Монголын ТМНБ–дын зөвлөлийн чухал асуудлыг нэгдсэн хуралдаанаар авч хэлэлцэх нь зүйтэй юм.

Монголын ТМНБ–дын зөвлөл нь нэгдсэн хуралдааныг зарлан хуралдуулахдаа хуралдаан болохоос хоёр долоо хоногийн өмнө хуралдаан болох өдөр цаг, газар, хуралдааны зорилгын талаар Монголын ТМНБ–дын зөвлөлийн дүрэмд заасны дагуу гишүүддээ бичгээр мэдэгдэнэ.

Монголын ТМНБ–дын зөвлөл нь нэгдсэн хуралдаанаараа зөвлөлийн дүрмийн өөрчлөлт, зөвлөлийн дүрэмд онцгойлон заасан зүйлийг гишүүдийн 2–ны 1–ээс дээш хувийн ирцтэйгээр, хуралдаанд суугчдын олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд санал тэнцүү хуваагдсан тохиолдолд хурлын тэргүүлэгчийн шийдсэнээр шийдвэрлэнэ. Гэхдээ зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг гишүүдийн 2–ны 1–ээс дээш ирцтэйгээр, 3–ны

2-оос доошгүй саналаар шийдвэрлэнэ.

ТМНБ нь нэгдсэн хуралдаанд биечлэн оролцож, хуралдаанд дэвшигдсэн асуудлын талаар өөрийн санал бодлоо илэрхийлэх шаардлагатай тул хуралдаанд сууж чадахгүй болсон этгээд нь хурлын хэлэлцэх асуудлыг хүлээн зөвшөөрч буй эсэх талаар тодорхой өгүүлсэн бичгийг хуралдаанд оролцогч этгээдэд итгэмжлэн ирүүлснээр хуралдаанд асуудал хэлэлцэх эрхтэй болно. Итгэмжлэх бичгээр хуралдаанд оролцох эрх бүхий этгээдийг нэгдсэн хуралдаанд оролцох ёстой гишүүдийн тоог тооцоолон гаргах үед хуралдаанд сууснаар тооцно. Тухайн тохиолдолд уг зөвлөлийн гишүүн нь ТМНБ-ийн зөвлөлөөс нэгдсэн хуралдаан зарлан хуралдуулах талаар урьдчилсан мэдэгдэл хүлээн авсан ТМНБ болох зөвлөлийн гишүүн байна.

Тавин есдүгээр зүйл

Нэгдсэн хуралдааны шийдвэрийг тайлагнах тухай

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-ийн нэгдсэн хуралдааны шийдвэрийг хэрхэн тайлагнах талаар заасан болно.

Монголын ТМНБ-дын зөвлөл нь ҮТЕГ-ын даргын хяналтан дор үйл ажиллагаагаа явуулдаг тул ТМНБ-дын зөвлөл нь нэгдсэн хуралдааны шийдвэр болон удирдах албан тушаалтныг томилох болон халах тухайгаа ҮТЕГ-ын даргад мэдэгдэнэ.

Жардугаар зүйл

Санал өргөн барих тухай

Тайлбар

Тус зүйлд Монголын ТМНБ-дын зөвлөлийн саналаа өргөн барих тухай болон хариу санал барих тухай заасан болно.

ТМНБ нь татварын албаны үйл ажиллагаа болон татварын системийн талаар өргөн мэдлэг бүхий татварын мэргэжилтэн тул ТМНБ-ийн бие даасан байгууллага болох ТМНБ-дын зөвлөлд өөрийн саналыг гаргаж, ҮТЕГ-ын даргад саналаа өргөн барихын зэрэгцээ түүнд хариу саналаа илэрхийлнэ.

ТМНБ-дын зөвлөл нь татварын алба болон татвар, ТМНБ-ийн системийн талаар саналаа тавьж болно. Түүнчлэн гаалийн татвараас бусад бүх татварын тогтолцоо болон бодлогын талаар саналаа өргөн барьж болно.

Саналаа өргөн барих гэдэг нь өөрийн зүгээс саналаа хэлж

илэрхийлэхийг хэлнэ.

ҮТЕГ нь ТМНБ-дын зөвлөлд тухайн татварын үйл ажиллагаа болон татварын бодлого ба ТМНБ-ийн тогтолцооны талаар санал гарган, ТМНБ нь тухайн саналд нь хариу санал гаргаж болно.

ТМНБ-дын зөвлөл нь Монголын ТМНБ-дын холбооны гишүүн байгууллага болох тул холбооны баримталж байгаа бодлоготой харшилдах санал гаргаж болох эсэх тухайд авч үзэхдээ ТМНБ-дын холбооноос тогтоосон зүйлийн талаар ТМНБ-дын зөвлөлүүд нь холбооны шийдвэрийг дагах ёстой гэсэн байр сууринаас хандах хэрэгтэй.

Жаран нэгдүгээр зүйл ТМНБ-дын холбоо

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-дын холбооны талаар заасан болно.

ТМНБ-дын холбоо нь аймаг, хотын татварын газар бүр дээр тус бүр байгуулагдах хуулийн этгээд болно.

Нийт улсын хэмжээн дэх ТМНБ-ийн зөвлөл нь Монгол улсын ТМНБ-дын холбоог байгуулж болох бөгөөд Монгол улсын ТМНБ-ийн холбоо нь нийт улсын хэмжээн дэхь ТМНБ-ийн зөвлөлийг өөрийн гишүүний эгнээнд элсүүлсэн хуулийн этгээд юм.

ТМНБ-дын холбооны зорилго нь ТМНБ-ийн өмнөө тавьсан эрхэм зорилгын дагуу ТМНБ-ийн үүргээ чанадлан биелүүлэх, ТМНБ-ийнхоо ажлыг үр бүтээлтэй урагшлуулахад нь хувь нэмэр оруулахын тулд гишүүдээ удирдлагаар хангаж, байнгын холбоотой ажиллаж, хяналт тавих үйл ажиллагааг явуулна.

ТМНБ-дын холбоо нь дээр дурдсан зорилгоо биелүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

[1.] ТМНБ-ийн зөвлөл болон гишүүдийн үйл ажиллагааг удирдах, холбоотой ажиллах, хяналт тавих ажилтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд ТМНБ-ийн зөвлөл болон гишүүдэд зөвлөгөө заавар өгөх

Энд өгүүлэх гишүүддээ хяналт тавих ажлыг Монголын ТМНБ-дын холбоо нь ТМНБ-ийн зөвлөлөөр дамжуулан явуулах ерөнхий зарчимтай юм. Тухайлбал, ТМНБ-дын холбоо нь ТМНБ-ийн зөвлөлийн гишүүнд арга хэмжээ авахдаа ТМНБ-ийн зөвлөлийн саналыг үл харгалзан шууд арга хэмжээ авах нь зохисгүй юм.

Энэ нь ТМНБ-дын холбооны гарал үүсэлтэй холбоотой асуудал бөгөөд Монгол улсын ТМНБ-дын холбооны гишүүд нь ТМНБ-дын зөвлөл байдаг тул ТМНБ нь уг холбооны дам гишүүн болдог. Үүнтэй

уядаад Монгол улсын ТМНБ–дын холбоо нь тухайн гишүүн болох ТМНБ–ийн зөвлөлийн гишүүн буюу ТМНБ–ийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхээ зарчмын хувьд ТМНБ–ийн зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Монгол улсын ТМНБ–дын холбоо нь ТМНБ–ийн зөвлөлийн санал дээр тулгуурлан холбогдох хяналтын эрхээ хэрэгжүүлэх болно.

2. ТМНБ–ийн зөвлөлийн тогтолцооны талаар хяналт шалгалт судалгаа явуулах

3. ТМНБ–ийн зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааг сайжруулах боловсронгуй болгох талаар шалгалт судалгаа явуулах

4. ТМНБ–ийн тогтолцоо болон ТМНБ–ийн үйл ажиллагааны талаар мэдээллийн сурталчилгааны ажил явуулах

5. ТМНБ–ийн зөвлөлийн ажлын тайланг гаргах

6. ТМНБ–ийн зөвлөлийн гишүүдэд зориулж сургалт семинар явуулах

7. ТМНБ–ийн зөвлөлийн зорилгыг биелүүлэхэд хэрэгтэй бусад үйл ажиллагаа явуулах

*Жаран хоёрдугаар зүйл
Монголын ТМНБ–дын холбооны дүрэм*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ–дын холбооны дүрмийн талаар заасан болно.

Монголын ТМНБ–дын холбооны дүрэмд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

1. Холбооны нэр болон албан конторын байршил
2. Эрх бүхий албан тушаалтантай холбогдсон заалт
3. Холбооны хурлын тухай дүрэм
4. ТМНБ–ийн нэр хүндийг өргөж явахтай холбогдсон заалт
5. Холбооны гишүүний хураамжийн тухай дүрэм
6. Ерөнхий ажил хэрэг болон санхүүгийн талаарх заалт

Монголын ТМНБ–дын холбооны дүрэмд орсон өөрчлөлтийг ҮТЕГ–ын даргаар батлуулаагүй тохиолдолд хүчингүй болно.

*Жаран гуравдугаар зүйл
Монголын ТМНБ–дын холбооны талаарх заалтыг хамааруулан
хэрэглэх тухай*

Тайлбар

ТМНБ–дын холбоо байгуулах, бүртгэл, удирдах албан тушаал, нэгдсэн хуралдаан болон нэгдсэн хуралдааны шийдвэрийг мэдэгдэж тайлагнахтай холбогдсон заалтад Монголын ТМНБ–дын холбооны

зохих заалтыг тэр хэвээр нь авч хэрэглэж болно. Гэхдээ ТМНБ-дын зөвлөл нь Монголын ТМНБ-дын холбооны гишүүн болох тул тухайн гишүүний эрх, зөвлөлд гишүүнээр элсэх, зөвлөлөөс гарах асуудлыг ТМНБ-дын холбооны дүрмээр зохицуулахгүй.

Монголын ТМНБ-дын холбооны гишүүн болох ТМНБ-дын зөвлөл дотор олон буюу харьцангуй цөөн тооны гишүүдтэй зөвлөл байх тул ТМНБ-дын холбооны нэгдсэн хуралдаанд нэг ТМНБ нэг санал хэлэлцүүлэх эрхтэй гэж заах нь зохисгүй юм. Иймд ТМНБ-дын холбооны нэгдсэн хуралдаанд санал өгөх эрхийг тогтоохдоо тухайн зөвлөлийн дүрмээр гишүүн болох ТМНБ-дын нийт тоонд тулгуурлан тогтоох хэрэгтэй.

Жаран дөрөвдүгээр зүйл

Нэгдсэн хуралдааны шийдвэрийг хүчингүй болгох болон эрх бүхий тушаалтныг албанаас нь чөлөөлөх тухай

Тайлбар

Тус зүйлд ҮТЕГ-ын даргын ТМНБ-дын зөвлөл болон Монголын ТМНБ-дын холбооны талаар тавих гол гол хяналтын ажлын тухай заасан болно.

Монголын ТМНБ-дын холбоо болон ТМНБ-дын зөвлөлийн үйл ажиллагаа татварын албаны үйл ажиллагаанд их нөлөөлдөг тул тухайн үйл ажиллагаанд хяналт тавих тухай холбогдох заалтыг хуулинд оруулсан болно. Монголын ТМНБ-дын холбоо болон ТМНБ-дын зөвлөлийн нэгдсэн хуралдааны шийдвэр болон удирдах ажилтны үйлдэл нь хууль тогтоомж, Монголын ТМНБ-дын холбоо болон ТМНБ-дын зөвлөлийн дүрэмд харшилж, улмаар хор хохирол учруулж буй тохиолдолд ҮТЕГ-ын дарга тус нэгдсэн хуралдааны шийдвэрийг хүчингүй болгож, тухайн удирдах албан тушаалтныг ажлаас нь чөлөөлөх тушаал гаргана.

Жаран тавдугаар зүйл

Ерөнхий хяналт

Тайлбар

Тус зүйлд ҮТЕГ-ын даргын ТМНБ-дын зөвлөл болон Монголын ТМНБ-дын холбооны үйл ажиллагаанд тавих ерөнхий хяналтын талаар заасан болно.

ҮТЕГ-ын дарга нь өмнөх зүйлд заасан Монголын ТМНБ-дын холбоо болон ТМНБ-дын зөвлөлд хяналт тавих онцгой эрхтэйгээс гадна Монголын ТМНБ-дын холбоо болон ТМНБ-дын зөвлөлийн үйл

ажиллагаа нь улс, орон нутгийн олон нийтийн байгууллага болон ердийн татвар төлөгчид ихээхэн нөлөөлдгийг бодолцон үзэж, тухайн үйл ажиллагааны зохистой байдлыг хангахын тулд шаардлагатай тохиолдолд эдгээр байгууллагын саналыг сонсож, тухайн үйл ажиллагаанд нь зөвлөмж заавар өгч, эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны байдал, данс тооцооны бичиг баримт, бусад зүйлсэд шалгалт явуулна.

*Есдүгээр бүлэг
ТМНБ-ийн ажлын хөлс*

*Жаран зургадугаар зүйл
ТМНБ-ийн ажлын хөлс*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-ийн ажлын хөлсний талаар заасан болно.

ТМНБ нь ТМНБ-ийн үйл ажиллагаа явуулж зохих цалин хөлс авах бөгөөд тухайн ажлын хөлсний талаарх заалтыг мэргэжлийн зөвлөлөөс тогтоох болно.

*Аравдугаар бүлэг
Бусад үндэслэл*

*Жаран долдугаар зүйл
ТМНБ-ийн ажил эрхлэх хязгаар*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-ийн ажил эрхлэх хязгаарын тухай заасан болно.

ТМНБ бус этгээд ТМНБ-ийн хуулиар онцгойлон зөвшөөрөөгүй тохиолдолд ТМНБ-ийн ажил эрхэлж үл болно.

ТМНБ-ийн ажил нь төр, олон нийтийн байгууллага, ердийн татвар төлөгчид ихээхэн нөлөөлдөг олон нийтийн шинж давамгайлсан ажил тул ТМНБ-ийн ажил эрхлэх хязгаарын тухай заалтыг тусгайд нь гаргаж ирсэн юм.

ТМНБ-ийн гүйцэтгэх ажил нь 2-р зүйлд заасан ажил болно.

Эдгээр заасан ажлаас гадуур ажил хийсэн этгээдийг 2 жил хүртэлх хугацаагаар хорих, эсвэл, 30 мянга хүртэлх төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

*Жаран наймдугаар зүйл
Нэр хэрэглэх хязгаар*

Тайлбар

Тус зүйлд ТМНБ, ТМНБ-ийн албан контор, Монголын ТМНБ-дын холбоо болон ТМНБ-дын зөвлөлийн нэрийг хэрэглэх хязгаарын тухай заасан болно.

ТМНБ-ийн ажлыг ТМНБ зөвхөн дагнан явуулах тул ТМНБ болон ТМНБ-ийн албан конторын нэрийг ТМНБ бус этгээд ашиглахыг хориглох тухай хуулинд заах хэрэгтэй. ТМНБ-ийн нэрэнд ТМНБ-ийн онцгой эрх агуулагдаж байдаг тул тухайн нэрийг хамгаалах шаардлагатай.

Үүнтэй нэгэн адилаар ТМНБ-дын холбоо болон ТМНБ-дын зөвлөлийн нэрийг бусад этгээд хэрэглэхийг хориглож, хамгаалах хэрэгтэй.

Жаран есдүгээр зүйл

ТМНБ-ийн хөлслөн ажиллуулж буй этгээдийн нууц хадгалах үүрэг

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-ийн хөлслөн ажиллуулах этгээд тухайн ажил үүрэгтэйгээ холбогдох нууцыг хадгалах үүрэг хүлээх талаар заасан болно.

Ажлаа хийх явцдаа олж мэдсэн нууцыг ТМНБ нь зохих шалтгаангүйгээр бусдад задруулж, ашиглаж үл болох (Тус хуулийн 31-р зүйл) тухай заалт байдаг бол ТМНБ-ийн хөлслөн ажиллуулж буй этгээдийн хувьд ч мөн үүнтэй ижил нууц хадгалах үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл, ТМНБ-ийн хөлслүүлж ажиллуулж буй этгээд болон бусад ажилтан нь ажил хийх явцдаа мэдэж авсан нууцыг зохих шалтгаангүйгээр бусдад задруулж, ашиглаж үл болох бөгөөд ТМНБ-ийн дэргэд хөлслөгдөн ажиллахаа больсны дараа ч энэхүү үйлдлийг хийж үл болно.

"Зохих" гэдэг нь тухайн этгээдийн зөвшөөрлийг авсан тохиолдол, эсвэл, шүүхэд гэрчээр татагдан, энэхүү нууцыг хэлэх шаардлагатай болсон тохиолдлыг хэлэх бөгөөд энэ тохиолдолд ТМНБ-ийн нууцыг хадгалах үүргээ зөрчихгүй хэмжээнд зохих мэдээлэл өгч болно.

Далдугаар зүйл

Хяналт тавих арга хэмжээ

Тайлбар

Тус зүйлд ТМНБ-ийн талаар ҮТЕГ-ын даргын авч явуулах хяналтын арга хэмжээний тухай заасан болно.

ҮТЕГ-ын дарга нь ТМНБ-ийн ажлыг зохих ёсоор явуулахын тулд шаардлагатай тохиолдолд ТМНБ-оос ажлын тайлан мэдээ авч,

ажилтнуудаараа ТМНБ–д асуулга явуулж, данс тооцооны баримт бичигт шалгалт хийлгэнэ. ҮТЕГ–ын дарга нь аймаг, нийслэлийн татварын газар болон сум, дүүргийн татварын хэлтсийн даргад өөрийн явуулах ажлынхаа зарим нэг хэсгийг даалган хийлгэх бүрэн эрхтэй. (Хуулийн 71–р зүйл)

Энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд ТМНБ нь ажлын тайлан мэдээгээ гаргахгүй байх буюу худал тайлан мэдээ гаргасан, татварын ажилтны асуултад хариулахгүй, эсвэл, худал хариулт өгсөн, шалгалтаас татгалзах болон саад учруулсан тохиолдолд 50 мянга хүртэлх төгрөгийн торгууль ногдуулна.

Далан нэгдүгээр зүйл
Ажил даалган хийлгүүлэх тухай

Тайлбар

Тус зүйлд ТМНБ–ийн хуулиар заах ҮТЕГ–ын даргын хийх ажлын зарим нэг хэсгийг аймаг, хотын татварын газар болон сум, дүүргийн татварын хэлтсийн даргад даалган хийлгэж болох тухай болон тэдгээр ажлын тухай заасан болно.

ҮТЕГ–ын дарга нь аймаг, нийслэлийн татварын газар, сум, дүүргийн татварын хэлтсийн даргад дараах ажлыг даалган хийлгэж болно.

1. Аймаг, нийслэлийн татварын газрын даргаар хийлгэх зүйл
 - 1) ТМНБ–оос ажлын тайлан мэдээ авах
 - 2) ТМНБ–д асуулга хийж, ажлынх нь холбогдолтой данс бүртгэлд шалгалт хийх
2. Сум, дүүргийн татварын хэлтсийн даргад даалган хийлгэх ажил
 - 1) ТМНБ–оос ажлын тайлан мэдээ авах
 - 2) ТМНБ–д асуулга явуулж, ажлынх нь холбогдолтой данс бүртгэлд шалгалт явуулах

Арван нэгдүгээр бүлэг
Ял шийтгэлтэй холбогдох заалтууд

72–78 дугаар зүйл

Тайлбар

ТМНБ–ийг шийтгэх ял шийтгэлийн дотроос хамгийн хүнд нь ТМНБ татвараас зайлсхийх талаар заавар зөвлөгөө өгсөн тохиолдолд 3 хүртэлх жилийн хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх хорих ял шийтгэх, эсвэл 1 сая хүртэлх төгрөгийн торгох ял юм. (Тус хуулийн 72 дугаар зүйл)

ТМНБ-ийн ажил эрхлэх хязгаарын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдийг 2 жил хүртэлх хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх хорих ялаар, эсвэл 300 мянга хүртэлх төгрөгийн торгох ялаар шийтгэнэ. (Тус хуулийн 73 дугаар зүйл)

ТМНБ болон ТМНБ-ийн хөлслөн авсан этгээд нь нууцыг хадгалах үүргээ зөрчсөн тохиолдолд 2 хүртэлх жилийн хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх хорих ялаар, эсвэл 200 мянга хүртэлх төгрөгийн торгох ялаар шийтгэгдэнэ. Гэхдээ тухайн хэргийн талаар зарга үүсгэсэн тохиолдолд уг шийтгэлийг оногдуулна. (Тус хуулийн 74 дүгээр зүйл)

① Төр, орон нутгийн олон нийтийн байгууллагын ажил эрхлэх этгээд ТМНБ-ийн ажил эрхэлж байгаа тохиолдолд болон тухайн ТМНБ-ийн үүрэгт ажлаасаа гадна бусад ажил эрхэлж буй этгээд ТМНБ-ийн үйл ажиллагаагаа зогсоох ёстой хэдий ч ТМНБ-ийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн эрхэлж буй тохиолдолд (Тус хуулийн 37 дугаар зүйл)

② ТМНБ-ийн ажил эрхлэхийг нь зогсоох сахилгын арга хэмжээнд буй этгээд үүнийг зөрчин ТМНБ-ийн үйл ажиллагаа дур мэдэн эрхэлж буй тохиолдолд (Тус хуулийн 39–40 дүгээр зүйл) 1 жил хүртэлх хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх хорих ялаар, эсвэл 200 мянган төгрөгийн торгох ялаар шийтгэнэ. (Тус хуулийн 75 дугаар зүйл)

ТМНБ болон ТМНБ-ийн албан контор, ТМНБ-дын зөвлөл, Монголын ТМНБ-дын холбооны нэр хэрэглэхийг хориглосон хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тохиолдолд тухайн гэм буруутай этгээдийг 200 мянга хүртэлх төгрөгийн торгох ялаар шийтгэнэ. (Тус хуулийн 68 дугаар зүйл)

ТМНБ болон ТМНБ-дын зөвлөл, Монголын ТМНБ-дын холбоо нь хяналтын арга хэмжээний талаарх хуулийн холбогдох заалтын дагуу ажлын тайлан мэдээ гаргаагүй буюу шалгалтанд орохоос татгалзсан буюу зайлсхийсэн тохиолдолд тухайн этгээдийг 100 мянга хүртэлх төгрөгийн торгох ялаар шийтгэнэ (Тус хуулийн 77 дугаар зүйл).

Эдгээр зөрчлийг хуулийн этгээдийн нэр дээр, эсвэл ТМНБ-ийн хөлслөгдөн ажиллаж буй этгээд гаргасан тохиолдолд хэрэг хийсэн этгээдийг шийтгэхийн зэрэгцээ тухайн хуулийн этгээд болон хөлслөн ажиллуулж буй этгээдэд ч бас шийтгэл оногдуулна. (Тус хуулийн 78–р зүйл)

JICA